

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “БЭРХ-УУЛ” НЭРТЭЙ
MV-012325A ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙД 2023 ОНД
ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**Улаанбаатар
2023**

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБЗГ-ын ахлах мэргэжилтэн...../С. Солонго/

**ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “БЭРХ-УУЛ” НЭРТЭЙ
MV-012325A ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙД 2023 ОНД
ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР MV-012325A/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР 9019089073/

Хянасан:

ТАБООАЖГ-ын ахлах мэргэжилтэн...../С. Эрдэнэцогт/

Биелэлтийг тайлагнах үүрэг хүлээсэн:

“Цүй Ханг инвест” ХХК-ийн Ерөнхий захирал...../Хуан Юнжис/

Боловсруулсан:

“Цүй Ханг инвест” ХХК-ийн ХАБЭАХ-ийн инженер...../Б. Пүрэвбат/

“Цүй Ханг инвест” ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн...../Н. Одончимэг/



2023 он

АГУУЛГА

1. ОРШИЛ.....	5
2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	6
3. ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТҮҮХ.....	13
3.1. Ордын геологийн тогтоц	14
3.2. Ордын тектоник	16
4. УУРХАЙН ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ	17
4.1. Цаг уур, уур амьсгалын онцлог.....	17
4.2. Агаарын температур	18
4.3. Хур тунадасны горим.....	19
4.4. Салхи, шуурга.....	19
5. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	21
6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ХҮРЭЭНД СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭГ АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН НЬ.....	22
6.1. Агаар орчныг сөрөг нөлөөлөлийг бууруулах арга хэмжээний биелэлт	22
6.2. Усан орчны сөрөг нөлөөлөлийг бууруулах арга хэмжээний биелэлт	22
6.3. Ургамлан орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	25
6.3.1. Ургамалжилтын онцлог, өнөөгийн төлөв байдал	26
6.3.2. Ургамлын бичиглэл №01 “Биелэг алаг өвс ба биелэг-улалж-алаг өвст бүлгэмдэл”	28
6.3.3. Ургамлын бичиглэл №02 “Улалж-үетэн алаг өвст бүлгэмдэл”	29
6.4. Хөрсөн бүрхэвчийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	31
6.4.1. Хөрсний зүсэлтийн бичиглэл №01	32
6.4.2. Хөрсний зүсэлтийн бичиглэл №02	35
6.4.3. Хөрсөн дэхь хүнд металлын шинжилгээний дүн.....	39
7. ДҮЙЦҮҮЛЭН НӨХӨН СЭРГЭЭЛТ БОЛОН ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	40
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ..	44
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	44
10. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	44
11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	44
12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	45
13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ.....	47
14. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	48
15. ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУД	49

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. MV-012325А ашиглалтын хайгуул хийх талбайн солбилцол	6
Хүснэгт 2. Агаарын хэмжилтийн төрөл	22
Хүснэгт 3. Усны шинжилгээний дүн	24
Хүснэгт 4. Төслийн талбайд зонхилон тааралдах ургамлын зүйлийн жагсаалт	30
Хүснэгт 5. Хөрсний дээжид задлан шинжилгээ хийсэн арга, нарийвчлал	31
Хүснэгт 6. Хөрсний химийн шинж чанар.....	33
Хүснэгт 7. Хөрсний механик бүрэлдэхүүн.....	33
Хүснэгт 8. Хөрсний химийн шинж чанар.....	36
Хүснэгт 9. Хөрсний механик бүрэлдэхүүн.....	36
Хүснэгт 10. Хөрсөн дэхь хүнд металлын агууламж	39

Зургийн жагсаалт

Зураг 1. Бэрх-Уулын ордын байршлын зураг	7
Зураг 2. Газар ашиглалтын ангилал.....	8
Зураг 3. Газрын гадарга	8
Зураг 4. Төсөл хэрэгжих талбайн хөрсний хэв шинж	9
Зураг 5. Төсөл хэрэгжих талбайн ургамлан бүрхэвч	10
Зураг 6. Заамар сумын ойн зураглал.....	10
Зураг 7. Газар доорхи усны давхарга.....	12
Зураг 8. Цаг уурын ОЖД мэдээ.....	17
Зураг 9. Төслийн талбай орчмын агаарын температур 1920-2020	18
Зураг 10. Хур тунадасны горим 1920-2020 (Төслийн талбай орчим).....	19
Зураг 11. Салхины дундаж хурдны жилийн явц.....	20
Зураг 12. Заамар сумын нутаг дах шороон шуургатай өдрийн тоо.....	20
Зураг 13. Монгол орны ургамал газарзүйн тойрог	26
Зураг 14. Төслийн талбайн ургамалжилтын хэв шинжийн тархалт.....	27
Зураг 15. Т-1 Ил уурхайн карьер орчмын ургамлын бичиглэл.....	28
Зураг 16. Т-2 Отваль орчмын ургамлын бичиглэл.....	29
Зураг 17. Хөрсний зүсэл-1	33
Зураг 18. Хөрсний зүсэлт-2	37
Зураг 19. Техникийн нөхөн сэргээлт хийхийн өмнө-1	40
Зураг 20. Техникийн нөхөн сэргээлт хийхийн өмнө-2	41
Зураг 21. Техникийн нөхөн сэргээлт хийхийн өмнө-3	41
Зураг 22. Техникийн нөхөн сэргээлт хийж буй явц.....	42
Зураг 23. Техникийн нөхөн сэргээлт хийсэний дараа-1	42
Зураг 24. Техникийн нөхөн сэргээлт хийсний дараа-2.....	43
Зураг 25. Техникийн нөхөн сэргээлт хийсний дараа-3.....	43
Зураг 26. Хөрс хамгаалалт	44
Зураг 27. Сургалтын үеийн.....	48

1. ОРШИЛ

Төв аймгийн Заамар сумын нутаг дахь Бэрх уулын алтны үндсэн ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн нэмэлт тодотголыг 2007 онд хийсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан ба 2009 онд боловсруулсан ТЭЗҮ-г үндэслэж 2015 онд нэмэлт тодотгол хийж боловсруулсан байна.

2018 оноос “Цүй Ханг Инвест” ХХК тухайн ордыг ашиглах эрхийг өөрийн нэр дээр зохих журмын дагуу холбогдох байгууллагуудаас авсан болно. “Цүй Ханг Инвест” компани Бэрх уулын ордын ТЭЗҮ-г дахин боловсруулахаар ажилласан бөгөөд 2019 оны 12 дугаар сарын 12-ны Т/19-16-03 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн 2020 оны 02 сарын 28-ны өдрийн АМГТГазрын даргын тушаалаар ТЭЗҮ-ний тодотголыг хүлээн аван батласан, батлуулсан ТЭЗҮ-г үндэслэн 2021 оны уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан ажилласан.

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу техникийн болон биологийн нөхөн сэргээлт, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийг хийсэн. Ашиглалтын хугацаа, нөөц бага тул БЭРХ-УУЛ ордын хүдрийг “ТЭН ХУН” ХХК харьяа Нарантолгойн алтны уурхайн уулын баяжуулах үйлдвэрт боловсруулах нь эдийн засгийн болоод байгаль орчныг хамгаалах болон бусад олон давуу талыг “Цүй Ханг Инвест”компанид олгосон.

Бэрх-Уул орд нь хөрс хуулалт + хүдэр олборлолт + хаалт/ нь 2,5 жилийн дотор бүрэн багтах бөгөөд уулын бүх ажлыг (ӨТА, хөрс хуулалт, хүдэр олборлолт, баяжуулалт) туслан гүйцэтгэх компануудаар хийж гүйцэтгүүлнэ. Ил уурхай нь спираль хэлбэртэй ,ажлын бус берм нь тээврийн замд ашиглагдана.

Бэрх-Уул алтны үндсэн ордыг ашиглах ТЭЗҮ-ийн нэмэлт тодотголоор ил уурхайн гүнийг +943м түвшин хүртэл нэмэгдүүлж тогтоогдсон нөөцийг бүрэн олборлохоор тусгажээ. Ил уурхай нь спираль хэлбэртэй, ажлын бус берм нь тээврийн замд ашиглагдана.

Төслийн нийт хөрөнгө оруулалт 1,8 тэрбум орчим төгрөг ба үүнээс тоног төхөөрөмжийн худалдан авалт, түрээсэнд 60 хувь, кемп болон бусад төрлийн барилга байгууламж 28 хувь байх бөгөөд хөрөнгө оруулалтаа 0,8 жилийн дотор нөхөн төлнө.Ашиглалтын хугацаанд 12,8 тэрбумын цэвэр ашигтай ажиллаж 6,0 тэрбум төгрөгийн татварыг улс, орон нутгийн төсөвд төвлөрүүлэн төлөх юм.

2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Бэрх-Уул нэртэй 12325А тоот 506 гектар хэмжээтэй ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь (Зураг №1) Улаанбаатар хотоос баруун тийш 230км, Төв аймгийн Заамар сумаас хойш 67км зайд оршино. Зам харилцааны хувьд дээрх суурин газруудтай шороон замаар холбогдох бөгөөд Аргалант сум хүртэлх асфальтан зам 125км зайд, Улаанбаатар-Булган-Хөвсгөлийн чиглэлийн төв замын төмөр бетонон гүүр 66км, зайд оршдог.

Газрын гадарга: Ордын талбай нь Хэнтий уулархаг мужийн баруун төгсгөлд дунд ба намхан уулархаг районд далайн түвшингээс дээш 890-1020 м өндөрт оршино. Рельефийн хувьд хөндий, хоолойгоор тусгаарлагдсан уулс, толгод бүхий гадаргатай.


Орхон голын баруун цутгал болох Туул гол нь талбайд хамгийн ойрхон том гол юм. Ордын талбайд хамгийн ойр хагас механикжсан ундны зориулалттай худаг баруун урагш 2 км-т оршино. Олон жилийн цэвдэгийн талаар мэдээ байхгүй.

Цаг уурын хувьд Монгол орны бусад нутгийн адил эх газрын эрс тэс хуурай уур амьсгалтай. Улирлын чанартай хөрсний хөлдөлт 2.5 м хүрнэ.

Дэд бүтцийн хувьд Дархан хотоос баруун урагш 170 км, Эрдэнэт хотоос зүүн урагш 120 км зайд тус тус оршдог ба ордын эргэн тойронд 70 км хүртэлх зайд Заамар сумын төв, Ар уртын баг, “Шижир Алт” компаний тосгон байрладаг. Ордоос урагш 10-15 км зайд “Мон Полимет” ХХК-ийн Тосонгийн дэнжийн уурхайн 0.6 кв өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам өнгөрнө. Топографийн планшетын хувьд 1:100 000 М-48-138 хавтгайд орших бөгөөд талбайн булангийн солбилцлүүдийг доорхи хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 1. MV-012325А ашиглалтын хайгуул хийх талбайн солбилцол

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	104	35	40	48	31	40
2	104	35	40	48	33	00
3	104	37	20	48	33	00
4	104	37	20	48	31	40
Нийт 506.47 га						



Зураг 2. Газар ашиглалтын ангилал

Төсөл хэрэгжих талбай нь газар ашиглалтын ангилалаараа хөдөө аж ахуйн бүс нутагт хамрагдаж байна.




Зураг 3. Газрын гадарга

Хөрсөн бүрхэвч: Төслийг хэрэгжүүлэх явцад хөрсөн бүрхэвчийн сөрөг нөлөөлөлд өртөгдөх байдлыг авч үзэхэд төсөл хэрэгжих талбайн шимт хөрсийг хуулах, хуулсан шимт хөрсийг нөхөн сэргээлтэнд зориулан овоолго хийж хадгалах, шимт хөрсний овоолгод дарагдах, түүнчлэн бусад барилга байгууламжид дарагдах, уурхайн үйл ажиллагаа явагдах талбайд хөрсөн бүрхэвч элэгдэх нөлөөлөлд өртөгдөнө. Төслөөс хөрсөн бүрхэвчид нөлөөлөх байдлыг хөрсний төрлөөр авч үзвэл:

- Төслийн талбайн зүүн хойд хэсэгт нийт талбайн 10 орчим хувьд нунтаг карбонатлаг ба карбонатгүй нимган хар хүрэн хөрс
- Талбайн 90 орчим хувьд нь нунтаг карбонатлаг цайвар хүрэн хөрс нөлөөлөлд өртөхөөр харагдаж байна.

Ил уурхай болон тэдгээрийн ойролцоох байгууламжууд, тосгон зэрэг уурхайн ихэнхи объектууд байрлах нунтаг карбонатлаг цайвар хүрэн хөрстэй талбайд байрлахаар харагдаж байна.




Зураг 4. Төсөл хэрэгжих талбайн хөрсний хэв шинж


Ургамлан нөмрөг: Энэ нутаг нь Монгол орны ургамлан нөмрөгийн хувьд ойт хээрийн бүсэд багтах бөгөөд уулс хоорондын хөндий, бэлийн хялганат хээрийн төрхтэй юм. Голын хөндийн татмын нугад газрын гадаргуугийн хотгор, гүдгэрийн байдал, хөрсний бүтцээс шалтгаалан янз бүрийн эвшил бүрэлдэх бөгөөд энд зонхилон тохиолдох үетэн-алаг өвст эвшилд мөлхөө хиаг, дагуур цагаан сул, нангиад цагаан суль-түнх, Монгол улаан толгой, буурцагтнаас хулгана гиш / *Vicia саасса L* / элбэг

тохиолдоно. Мөн голын ирмэг, хөвөөгөөр болон шаварлаг, ус тогтсон хонхор хотгорт дов сондуул, намгархаг нуга, хайрга чулуутай хэсэг тохиолдож байна.

Төсөл хэрэгжих нийт талбайн зүүн хойд хэсгийг буюу 45 орчим хувийг хялгана хиагт-алаг өвст, 55 орчим хувийг харгана оролцсон хялгана-ботууль-алаг өвст хэв шинжийн ургамалжилттай байна.



Зураг 5. Төсөл хэрэгжих талбайн ургамлан бүрхэвч



Зураг 6. Заамар сумын ойн зураглал

Төсөл хэрэгжих талбайн нь байгалийн аясаар доройтолд өртсөн өнгөн хөрс нь суларсан, ургамалжилтын хувьд хөл газрын ургамал давамгайлсан, ургамлын бүрхэц болон үндэслэг шинж нь бага байсан.

Усны нөөц, чанар: Бэрх-Уулын алтны үндсэн орд нь байршлын хувьд Монгол орны гадаргын усны ай савын хуваарилалтаар Хойд мөсөн далайн ай савын Сэлэнгэ мөрний сав газарт хамаарна. Сэлэнгэ мөрний сав газарт Хэнтий, Хангай нуруу түүнээс эх авч урссан том, жижиг голууд чухал үүрэг гүйцэтгэнэ. Төсөл хэрэгжих газарт хамгийн ойр урсах /1.5 км/ Туул гол нь Хан Хэнтийн нурууны далайн түвшнээс дээш 2000 гаруй метрт орших Чисаалайн сарьдаг, Шороотын давааны өврөөс гарах Намъя, Нэргүй хоёр голын уулзвараас эх авна. Хэнтийн нурууны ам хөндий салбар уулсаас эх авсан Галтай, Баруун, Зүүн Баян, Тэрэлж, Хагийн гол, Улиастай, Сэлбэ, Бөхөг-Түргэний гол зэрэг олон гол горхи нийлнэ.

Газрын доорхи ус: Төсөл хэрэгжиж байгаа район нь газар доорхи усны мужийн ангилалаар түр зуурын элбэг тэжээлтэй ангилалд ордог. Ордын талбайн газрын доорх ус агуулагч чулуулгийн байрлал литологийн найрлагаас хамаарч талбайн уст бүрдлүүдийг 1-т дөрөвдөгчийн сэвсгэр хурдасны газрын доорх ус, 2-т эрт төрмөлийн тунамал-метаморф чулуулгийн ан цавын газрын доорхи ус гэж ангилна.

Дөрөвдөгчийн сэвсгэр хурдасны газрын доорх ус нь маш өргөн тархалттай, Туул голын хөндий, түүний цугалуудын татам, дэнжүүдийн хурдастай холбоотой. Дөрөвдөгчийн хурдасыг аллювийн гаралтай элс, шаврын барьцалдуулагчтай хайрга, хайрганцар бүрдүүлнэ. Тэдгээр хурдсыг делюви-солифлюкцийн гаралтай хэмхдэс, үйрмэг агуулсан шавранцар хучиж байх нь элбэг. Эдгээр уст хурдсууд 0.4-3.0 м хүртэл зузаантай элюви дээр оршино. Элювийн хурдас нь элс, хааяа шавранцар, шавар барьцалдуулагчтай хэмхдэс, үйрмэгээс тогтоно. Ус шүүрэлтийн коэффициент 10-82 м/хон, цэнгэг, эрдэсжилт 0.4 г/л-ээс бага. Химийн найрлагын хувьд гидрокарбонат-кальци-натри эсвэл гидрокарбонат-натри-магнийн төрөлд багтана.

Эрт төрмөлийн тунамал-метаморф чулуулгийн ан цавын газрын доорх ус нь палеозойн Хараагийн группын шаварлаг занар, алевролит, элсжингийн ан цавд байрлана. Шүүрэлтийн коэффициент 5.5 м/хон, химийн найрлагын хувьд гидрокарбонат-кальцийн төрөлд багтана. Ус нь агаар мандлын усаар тэжээгдэнэ. Газрын доорх ус нүүрс хүчлийн хий болон хүчил, сульфат, магни зэрэг идэмхий агуулагч байхгүй. Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн кальцийн бүлгийн, 2-р төрлийн чанарын хувьд цэнгэг зөөлөвтөр ус болно. Шинжлэх ухааны академийн геоэкологийн хүрээлэнгийн усны шинжилгээний лаборатори шинжилгээн дээрх үзүүлтүүдээрээ ундны усны стандартын шаардлагыг хангаж байна гэж дүгнэсэн байна. Ордын талбайд олон жилийн цэвдэг байхгүй.

Ордын орчмын талбайд хүн, техникийн хөдөлгөөнөөр ургамлыг нь талхлаж, хөрсийг нягтруулбал газрын гадаргын ус шингээх чадвар багасч шар усны болон зуны хур борооны үед тохиолдох үерийн хүчийг нэмэгдүүлэх, муруй шинжтэй болгох, хөрсний элэгдэл эвдрэлийг нэмэгдүүлэх болно. Үүнтэй уялдан гадаргын усны бохирдол нэмэгдэх магадлалтай. Ил уурхайн амруу гадаргын урсацаар ус орж болзошгүй байна. Тусгай зөвшөөрлийн талбайн хойд хэсгээр уулархаг хэсэгтэй байгаа нь овоолго шороог урсах, гадаргын урсацаар хөрс, ус бохирдох тохиолдол

гарч болно. Газрын гадарга дээр болон ил уурхайнд бохирдол үүсвэл хөрс, чулуулгийн ан цаваар дамжин газар доорх усанд орж болзошгүй.



Зураг 7. Газар доорхи усны давхарга

Амьтан: Заамар уулын районд Монголын Шинжлэх Ухааны Академийн ажилтан нар 1960-1980 оны хугацаанд хэд хэдэн удаа хайгуулаар ирж амьтны аймгийн судалгаа хийж байсан. Судалгаанд хөхтөн судлаач эрдэмтэн С. Дуламцэрэн, Д. Цэнджав, шувуу судлаач А. Болд, шавьж судлаач Б. Намхайдорж болон ОХУ-ын ШУА-ийн эрдэм шинжилгээний ажилтан нар оролцож байсан байна. Тус сумын нутагт хөхтөн амьтдаас халиун буга (Elk), бор гөрөөс (Siberian Roe Deer), саарал чоно (Gray Wolf), үнэг (Red Fox), хярс (Corsac Fox), шилүүс (Enrasian Lunx), дорго (Furaslan), мануул (Pallas Cat), өмхий хүрэн (Steppe or Siberian Polecat), бор туулай (Tolai Hare), үен, солонго зэрэг байна.

Дээрх жигүүртнүүдээс хар өрөвтас, гангар хун, хээрийн галуу, явлаг сар, усны нөмрөг бүргэд зэрэг шувууд Монголын улаан номонд орсон болно.

Хэнтийн уулс ойт хээр, уулын хээрийн бүсэд орших тул зарим амьтад өндөр уул руу өгсөж байрлах тохиолдол байдаг. Орд орчмын амьтны аймгийн үндсэн төлөөлөгч болох шувуу хөхтний бүрэлдэхүүн нь манай орны бусад уулархаг нутагтай харьцуулахад экологийн хувьд нэгэн жигд, цөөвтөр зүйлийн бүрэлдэхүүнтэй байна.

Авто зам түүгээр зорчих тээврийн хэрэгслийн өндөр хурдтай хөдөлгөөн нь орчны амьтдын байгалийн жамаараа үржих төллөх газар, бэлчээр, тэжээлээ сонгож улирлын аясаар ойр хол нүүж шилжих замд нь саад болно. Тус замаар зорчих тээврийн хэрэгслийн дуу чимээ, гэрэл, хүний хөл

хөдөлгөөн, утаа, тоос, шороо зэрэг нь ойр хавийн ан амьтны тайван идээшлэх, бэлчихэд саад болж дүрвэх, зайлахад хүргэж болзошгүй.

3. ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТҮҮХ

Заамарын талбайд алт олборлож байсан ул мөр байгаа нь бүр 1980-аад оны үеэс мэдэгдэж байсан бөгөөд энэ нь зарим хэвлэлд мэдээлсэнчлэн 11-12 дугаар зууны үед Монголын нутаг дэвсгэр дээр алт олборлож байсан тухай дурьдснаас үзэхэд тэр үеийн алт олборлолтын ул мөрч байж болох юм (Геология МНР, 1973).

Заамар хавийн геологийн анхны судгаа 1958 онд В.А. Батаевын удирдлаган дор хийсэн 1:100000 масштабын геологийн зураглал бөгөөд Заамарын нурууг хамарсан алтны сарнилын хүрээг илрүүлжээ. Илүү нарийвчлалтай судалгаа нь зөвхөн 1971 онд В.М. Якимов, П.В. Ламатханов нар 1:200000 масштабтай геологийн зураглалын ажил гүйцэтгэж талбайн геологийн тогтоцыг нилээд нарийвчлан тодруулж Заамарын нурууны хойд ба баруун хойд хэсэгт алтны үндсэн болон шороон илрэлүүдийг илрүүлсэн байна.

1973-1975 онд ГУУУЯ-ны геологийн үйлдвэрлэл, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс Хойд Хэнтийн алтжилтын бүсийн 1:500000 масштабын урьдчилсан металлогены зураг зохиож алтны орд илрэлүүдийг хүдрийн формацийн төрлөөр ангилан таамаг нөөцийн үнэлгээ өгсөнийн дотор Заамарын район багтжээ. 1979-1981 онд Дархан хотын Геологийн экспедици Заамарын нурууны хэсэгт 1:50000 масштабын геологийн зураглал, эрлийн ажил хийж алтны шороон ордын хувьд илүү их хэтийн төлөвтэй болохыг тогтоосноор алтны шороон ордын эрэл хайгуулын ажил эрчимжсэн байна.

1981 оноос эхлэн өнөөг хүртэл тасралтгүй хийсэн улсын төсвийн болон хувийн хөрөнгө оруулалтаар хийсэн эрэл хайгуулын ажлын үр дүнд Заамарын талбайд 30 гаруй алтны шороон болон алтны үндсэн 0987654321'1 ордуудыг илрүүлсэн нь Монгол орны алтны баталгаат нөөцийг дийлэнх хэсгийг бүрдүүлж алтны олон арван уурхай ажиллаж байна. 1982-1985 онд ГУУУШ хүрээлэнгийн эрдэмтэн Г. Дэжидмаа, Н.Я. Болотова-Шабаловская нар Хойд Хэнтийн бүсийн баруун хойд хэсгийн алтны шороон орд илрэлүүдийн үндсэн эх үүсгэвэр, тэдгээрийн хоорондын холбоо, үүсч бүрэлдсэн нөхцлийг судалсанаас гадна Заамарын нурууны палеозой, мезозойн хөрзөн чулуулгийн алтжилтын талаар сэдэвчилсэн судалгаа явуулж Заамарын хүдрийн зангилааны хэмжээнд алтны хүдэржилт мезозойн эринд үүсэн бөгөөд алтны хүдрийн биетүүдийн ихэнх нь Заамарын давхрагадасын хурдас тархсан талбайд тэмдэглэгдэх ба шороон орд илрэлүүдийн үндсэн эх үүсвэр нь алт агуулсан кварцын судлаас гадна эрдэсжсэн хоёрдогч хувирлын зурвасууд ихээхэн үүрэгтэй гэж үзсэн ба олон настны хөрзөн чулуулаг ямар нэг хэмжээгээр алт агуулдаг бөгөөд тэдгээрийн нас залуужих тусам алтны агуулга өсдөг болохыг тогтоосон байна. 1984-1985 онд А.Л. Шпильковын удирдлагаар Заамарын талбайд 1:50000 масштабын агаарын соронзон, гаммаспектрийн зураглал хийгджээ.

1987-1990 онд хуучнаар ЗХУ-ын ВСЕГЕИ хүрээлэнгийн эрдэмтэн В.В. Жданов, Б.А. Блюман нар Заамарын хүдрийн зангилаа болон Хойд Хэнтийн алтжилтын бүсийн хэмжээнд алтны хүдэржилт агуулсан метосоматит хувирлын чулуулгийн сэдэвчилсэн судалгаа, 1981-1994 онд Заамарын хүдрийн зангилааны зүүн өмнөд хэсэгт 1:50000 масштабын геологийн

зураглал, эрлийн ажлыг Л.Е. Эйдельман, Б. Пүрэвсүрэн, Ш. Энхбаатар нар хийж алтны хүдрийн олон тооны илрэлүүдийг тогтоон Заамарын талбайн алтжилт зүүн урагш тэлж өргөжих цар хүрээтэйг нотлон, илрүүлсэн алтны Бумбат, Нарийн голын талбайн хэтийн төлөвт үнэлгээ өгчээ.

2002 онд Монголын Геологийн албаны эрдэмтэн Г. Дэжидмаа нарын хийсэн Монгол улсын металлогений судалгааны үр дүнд Монгол улсын алтжилттэй талбайнуудын хил заагийг тогтоох оролдого хийсний дотор Заамарын хүдрийн зангилааны хил хүрээг хамгийн сүүлийн үеийн мэдээ материалыг ашиглан тогтоох оролдого хийсэн нь хайгуулын ажлын чиглэлийг тогтооход чухал ач холбогдолтой болсон байна.

Заамарын хүдрийн районд алтны ордуудын үндсэн эх үүсвэр нь Бумбат, Нарийн зэрэг хүдрийн зангилаануудад тархсан алттай кварцын судлууд нь илэрлийг 1972 онд Б.М. Якимов нарын Хараа группын метаморф чулуулаг, Бороо комплексийн интрузив биетийн хил зааг орчимд 8-10 м өргөнтэй хэдэн зуун метр урттай кварцын судлыг илрүүлэн сорьцлолт хийж алтны агуулгыг 2 г/тн, мөнгө 12.8 г/тн гэж тогтоожээ. 1990 онд Н.Н. Кузнецов, Пүрэвсүрэн нарын Орос-Монголын хамтарсан судалгааны хэсэг 1:50000 масштабын зураглалын ажил хийж уг илрэлийн алтны нөөцийг P1 зэргээр 3.2 тн гэжээ.

Бэрх-Уулын талбай нь Хойд Хэнтийн алтны бүсийн Заамарын хүдрийн зангилаанд хамаарагдах ба түүний геологийн тогтоц алт агуулсан кварцын судал болон хувирлын зурвас нь манай улсад ашиглагдаж буй алтны үндсэн орд Бумбат, Бороо, Гачууртын ордуудтай гарал үүсэл геологийн нөхцлийн хувьд төстэй юм. Иймд Бэрх-Уулын алтны судлын биетүүд нь дунд-дээд ордовикийн Бороо гол комплексийн саарал боржин болон габбро, габбро-диорит, диориттой холбоотойгоор үүссэн байна.

3.1. Ордын геологийн тогтоц

Дунд кембр-доод ордовик Хараа групп /E2-O1 nr/. Хараа группын хурдас нь сулхан метоморфизмд орсон терриген чулуулгаас бүрдэнэ. Энэ насны чулуулаг нь ордын талбайн 11.7%-ийг эзэлсэн ба түүний хоёр захаар илэрдэг 2 зузаалагтай. Талбайд зөвхөн доод зузаалагт хамрагдах янз бүрийн ширхэгт сулхан занаржсан хувирмал элсэн чулуу, шаварлаг-цахиурлаг-гялтгануурт занар, занарлаг алевролит тархсан байна.

Чулуулаг нь гүний интрузив биет болон кварц, кварц-турмалины судлаар зүсэгдсэн, заагийн хувиралд хүчтэй өртөн, мигматгтжиж роговикжсон байх нь түгээмэл. Хурдас чулуулаг нь ерөхийдаа шовх оройтой эгцдүү хажуутай толгодоор хадархаг гарш үүсгэж илэрдэг. Чулуулгийн үе нь зүүн урагш чиглэлд 40-60° налуутай моноклинали атираа үүсгэнэ. Интруз чулуулгийн заагт Хараа группын элсэн чулуу, алевролит зонхилж биотитотэвэр хуурмаг, эпидотжсон скарн мусковитжилт зэрэг хувиралд автсан байна.

Доод карбоны Өрмөгтэй формаци /c1ug/. Энэ формацийн хурдас нь судалгааны талбайн зүүн урд хэсгээр багахан талбайг эзлэнэ. Чулуулгийн найрлага нь элсэн чулуу, конгломерат, алевролитаас бүрдэнэ. Эдгээр нь ритмлэг тогтоцтой, ганц нэг бул чулуу бүхий жижиг дунд хайргат конгломератаас дээшлэх тусам гравелит бүдүүн том дунд мөхлөгт элсэн чулуу, алевролитод аажмаар шилжсээр нарийн үелэг /5-7 см/ тогтоцтой болно. Хайрга нь сайн

мөлгөржсөн бусад насны хувирмал бялхмал чулуулгууд болон гранит, гранодиорит, габбро болон бусад интруз чулуулгаас бүрдэнэ.

Дээд дөрөвдөгч орчин үеийн хурдас /QIII-IV/. Дээд плейстоцен-орчин үеийн сэвсгэр хурдас нь ордын талбайн өмнөд хэсэгт тархсан. Гарал үүслийн хувьд делюви-пролюви гаралтай бөгөөд уулсын бэл хормойн шлейф, жалга судгийн хошуурсан туугдас, өргөн хөндийнүүдийн хучаас хурдсыг бүрдүүлэгч огт мөлгөржөөгүй олон тооны хэмхдэс бүхий огт ялгаралгүй шавранцар голлосон хурдас юм. Боровтор саарал өнгөтэй хэмхдэс материал бага, маш бага хэмжээний хайрга бүхий шавранцар зонхилно. Хэмхдэс хайрганы хэмжээ нь 20-30%, хурдасны нийт зузаан 4-6 м орчим. Одоогийн байдлаар үйлдвэрлэлийн алтны агуулга бүхий орд илрэл тогтоогдоогүй байна.

Дунд-түрүү ордовикийн итруз Бороо гол комплекс /(v γ)O2-3b/-ын чулуулаг нь талбайд хамгийн өргөн тархалттай, ихэвчлэн боржин, диорит, габброгийн найрлагатай. Габбро, габбродиорит, диорит нь алтны илрэл орчим Хараа группын хурдсыг зүсэж хил заагийн нилээд хувиралд орж эрлийзжсэн байдалтай, ерөнхийдөө захын хэсгүүдээр жижиг биетүүдийг үүсгэх буюу рельефийн намссан хэсэг, хаяа гол фазын гранитоидод үлдэгдэл /ксенолит/ маягаар тохиолдоно. Энэхүү комплексын интруз чулуулгийг дараах фазад ялгав. Үүнд:

Нэгдүгээр фаз-габбро, габбро-диорит, диорит

Хоёрдугаар фаз-боржин, гранодиорит эдгээрийг ялгасан болно.

Нэгдүгээр фазад хамаарагдаж буй диорит нь ногоовтор саарал өнгөтэй, призмлэг ширхэгт структуртай, плагиоклаз-амфибол (эвэр хуурмаг) пироксен, плагиоклаз-биотит-эвэр хуурмаг-биотитын найрлагатай, аажмаар суурилаг болсоор габбро, габбродиорит шилжинэ. Габбро нь ихэнхдээ том ширхэгт, габбро структуртай, цул заримдаа таксит текстуртай хар ногоон өнгөтэй, алттай судлыг агуулагч гол фаз юм. Талбайн нилээд хэсгийг хоёрдугаар фазын дунд том ширхэгтэй боржин эзлэнэ. Биотит эвэр хуурмагт найрлагатай саарал, цайвар өнгийн дунд зэргийн ширхэгтэй, биотит эвэр хуурмаг-хээрийн жоншны хэдэн арван сантиметр хүрэх хэмжээтэй шпирүүдийг агуулдаг онцлогтой.

Эхний фазын габброидын чулуулагт эпидотжилт, хлоритжилт, кварцжилт, мусковитжилт зэрэг хувирал ихээхэн хөгжсөн, кварц-сульфидтэй, кварц-турмалинтай, кварц-калишпатын судлууд нилээд өргөн тархалттай. Хүдэржилтийн хувьд сульфид, алт-сульфидийн эрдэсжилттэй кварцын гол судлууд нь Бороо гол интрузив комплекс /δ1γ2γ3D/-ын чулуулаг нь талбайн баруун хойд хэсэгт, томоохон хөндийн зах орчмыг дагаж байрлана. Бэрх-Уулын өврөөр илэрсэн учир шинээр нэрлэгдсэн байна.

Талбайн хүрээнд тархсан девоны интруз биетүүд нь гурван фазын бүтэцтэй, харьцангуй сайн илэрцтэй, блоклог болон босоо хэсэгшилтэй гарш үүсгэнэ. Ялангуяа эхний фазын амфибол-биотитот диорит нь жижиг дунд ширхэгтэй бор ногоон туяат ногоон саарал өнгөтэй блоклог хэсэгшилтэй, хадан цохион гарш үүсгэж илэрсэн хийгээд Хараа группын терриген зузаалгийг болон Бороо гол комплексын гол фазын саарал гранитоидыг урж зүссэн хил заагтай.

3.2. Ордын тектоник

Бэрх-Уулын хүдрийн талбай нь Заамарын хүдрийн зангилааны баруун хойд залгаанд Баянголын гүний гол хагаралаас баруун хойш 15 км орчим зайд энэ хагаралтай зэрэгцээ байрлалтай түүний салбар хагаралаас зүүн урагш 4-5 км зайд эдгээр хагаралаар шилжсэн баруун хойшоо сунаж баруун урагшаа ялимгүй нумарсан хагарал болон түүний салбар хайрс маягийн хагаралуудын систем оршино. Орд орчмын геологийн зурагт сүүлчийн хагарлын систем сайн дүрслэгдсэн. Ялангуяа уулын бэлийг хөвөөлдсөн хагарал нь сансрын болон соронзон орны зурагт тодорхой харагддаг. Орд орчмоор хүдрийн биеттэй зэрэгцээ байрлалтай тектоник хагарлын үйлчлэл гадаргад, ялангуяа цооногт маш тодорхой илэрсэн. Нөгөөтэйгүүр баруун хойш, хойд чиглэсэн хагарал болон хүдрийн биетийг шилжүүлж зүүн хойш сунасан жижиг зөрөг хагарлууд тэмдэглэдэг. Иймхүү орд орчмоор янз бүрийн чиглэлтэй хагарлууд ихээхэн хөгжсөн нь ордын тогтоцонд нийлмэл байдлыг үзүүлэх нөлөөтэй байна.

Ажиллах хүч, техник хангамжийн тухай мэдээ: “Цүй Ханг Инвест” ХХК-ийн ерөнхий геологичийн удирдлаган доор гэрээгээр цохилтот өрөмдлөгийн ажлыг хийж гүйцэтгэх мэргэжлийн компанийн ажилтнуудыг ажиллуулсан.

Тухайн талбайд ажиллах хүчийг дунджаар тооцвол:

1. Ахлах геологич-1
2. Геологич-2
3. Жолооч-1
4. Туслах ажилтан-3
5. Хээрийн ангийн үйлчилгээнд-2 гэсэн нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй ажиллана.


Техник хангамж:

1. Ланд Крузер-1
2. Лаптоп-2
3. Цогцолбор-2 ширхэг сорьц авах багаж, дээжний уут болон бусад шаардагдах бараа материал байна.

4. УУРХАЙН ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

4.1. Цаг уур, уур амьсгалын онцлог

Төв аймгийн Заамар сум нь Монгол орны уур амьсгалын мужлалаар Хуурайдуу сэрүүн зунтай, бүсийн хахир өвөлтэй мужид хамаарах ба уур амьсгалын нөхцөлийн хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай бөгөөд хамгийн хүйтэн нь 1-р сард -37 хам хүрдэг бөгөөд 9-р сарын сүүл, 10-р сарын эхээр хүйтэрч эхэлдэг байна. 3-р сараас эхлэн мэдэгдэхүйц дулаарах хандлага гарах бөгөөд 4-р сард цасан бүрхүүл бүр мөсөн хайлж дуусна. Жилийн дундаж хур тунадас 360 мм болдог бөгөөд түүний 85% нь зуны улиралд унадаг байна. Талбайн хэмжээнд олон жилийн цэвдэг байхгүй боловч өвлийн улиралд хөрс 2-2.5 м хүртэл хөлддөг юм. Салхи голдуу хойт ба баруун хойт чиглэлтэй байх ба салхины жилийн дундаж хурд нь 3.5 м/сек бөгөөд 3-4-р саруудад салхины хурд 20 м/сек хүртэл хүрдэг байна. Орографийн хувьд район нь уулс хоорондын Туул голын хөндий, гадаргуугаас 900-1000 м үнэмлэхүй өндөрт байрлана. Талбай нь Туул голын баруун эргийн дагуу байрлах Заамарын нуруунд харьяалагдах бөгөөд энэ нурууны хамгийн өндөр нь 1816 м хүрдэг боловч Заамарын нурууны ихэнх оргилуудын үнэмлэхүй өндөр нь 1500-1700 м юм. Талбайн баруун хэсгээр Бүрэнгийн нурууны олон салбарласан усан хагалбар бүхий нам уулс байрших бөгөөд ихэнх оргилуудын үнэмлэхүй өндөр нь 1200-1300 м юм . хөндий болон жалгаас дээрх нурууны харьцангуй өндөршилт нь 100-150 м-ээс ихгүй байна.




Зураг 8. Цаг уурын ОЖД мэдээ

Цаг агаарын үзүүлэлтүүдийг CRU TS Version 4.06 Google Earth Interface програмын 2000-2023 оны мэдээнээс ашиглав. Эх газрын эрс тэс, хуурай нөхцөлд хүрээлэн буй орчны гол жолоодогч хүчин зүйл нь хур тунадас болдог. Төслийн талбай орчим жилийн турш хуурайшилтгүй. Жилийн дундаж агаарын температур нь 0.8 °C байгаа нь Монгол орны дунджаас 0.5 °C-аар дулаан ажээ. Хамгийн хүйтэн 1-р сар дунджаар -21.8 °C, 7-р сарын дундаж температур 19.7 °C. Нийт хур тунадасны 45.4% нь 7-8-р саруудад буудаг.

4.2. Агаарын температур

Монгол орны хэмжээнд жилийн дундаж агаарын температур 1940-2020 оныхооронд 2.4 °C-аар дулааржээ. Ер нь дэлхийн цаг агаарын дулаарал тус аймгийн нутагт ажиглагдаж байна. Тухайлбал, сүүлийн 45 жилийн хугацаанд жилийн дундаж агаарын температур 1.05 °C, дулааны улиралд 1.04 °C, хүйтний улиралд 1.53 °C-ээр тус тус нэмэгджээ.

Төсөл хэрэгжих талбай орчмын агаарын температурын параметрийг CRU TS Version 4.06 Google Earth Interface програмын 2000-2023 оны мэдээгээр авч үзэхэд олонжилийн дундаж температур 0.8°C. Хамгийн хүйтэн 1 дүгээр сард агаарын дундаж температур -21.8 °C, хамгийн дулаан 7 дугаар сард агаарын температур 19.7 °C хүрдэг байна.




Зураг 9. Төслийн талбай орчмын агаарын температур 1920-2020

Төв аймгийн 2022-2023 оны өвлийн улирлын цаг уурын тоймоос авч үзэхэд 2022 оны 12-р сар, 2023 оны 1-2-р сарын агаарын дундаж температур нийт нутгаар -13.9 °C, -24.2 °C байснаас Дэлгэрхаан суманд -13.9 °C, Алтанбулаг суманд -24.2 °C байв. Олон жилийн дундажтай харьцуулахад Зуунмод, Угтаал, Баян-Өнжүүл, Баянчандмань, Лүн, Жаргалант, Баянжаргалан, Цээл, Аргалант, Эрдэнэ, Өндөрширээт сумдын нутгаар -0.3 °C, -1.0 °C орчим, Баян, Мөнгөнморьт, Алтанбулаг сумдын нутгаар -1.1 °C, 2.2 °C-ээр хүйтэн, бусад сумдын нутгаар 1.3 °C, 2.5 °C-ээр дулаан байв.

Агаарын хамгийн их температур -5.1 °C, +10.7 °C байснаас 02 дугаар сарын 26-нд Бүрэн суманд +10.7 °C хүрсэн байна. Агаарын хамгийн бага температур -31.8 °C, 45.3 °C байснаас 01 дүгээр сарын 23-нд Алтанбулаг суманд -45.3 °C хүрч хүйтэрсэн байна. Агаарт 30 градус буюу түүнээс хүйтэрсэн өдрийн тоо 4-36 өдөр байсны 36 өдөр нь Алтанбулаг суманд ажиглагдсан.

4.3. Хур тунадасны горим

Монгол орны хэмжээнд нийт хур тунадас 1940-2020 оны хооронд 6% буурчээ. Жилийн тунадасны 3 хүрэхгүй хувь нь өвлийн улиралд ногдох ба цасны дундаж хэмжээ уулархаг нутгаар 30 мм-ээс бага, говь нутагт 10-аас хэтэрдэггүй. Учир нь өвлийн улиралд манай оронд эсрэг циклон ноёрхдог тул тунадас орох боломж бүрдэх нь бага байдагтай холбоотой. Сүүлийн 20 жилд хур тунадасны хэмжээ төслийн талбай орчим 38.7 ± 56.2 мм хооронд хэлбэлзэж байсан. өвлийн улиралд 15.6 мм, зуны сарууддаа 239.2 мм ордог байна. Харин намрын саруудын дундаж хур тунадас 66.7 мм, хаврын саруудын нийлбэр хур тунадас 65.2 мм байв.



Зураг 10. Хур тунадасны горим 1920-2020 (Төслийн талбай орчим)

Хоногийн хамгийн их хур тунадас олон жилийн дунджаар 6-р сард хамгийн их буюу 95.3 мм орж байсан бол сүүлийн жилүүдэд мөн 6-р сард 110.9 мм, 7-р сард 105.4 мм, 8-р сард 99.9 мм бороо орох нь ихсэж, намар орох хур тунадасны хэмжээ багасгах хандлагатай болсон нь харагдаж байна.

Монгол орны нутаг дээр жилийн хур тунадасны ихэнх нь зуны улиралд унах бөгөөд энэ зүй тогтол Заамар суманд ч ажиглагдаж байна. Аадар, зүсэр бороотой өдрийн тоог харьцуулахад сүүлийн жилүүдэд зүсэр бороотой өдрийн тоо багасаж, богино хугацаанд усархаг аадар тунадас ажиглагдах нь ихсэх төлөвтэй байна.


Мөн хур тунадасны хуваарилагдалт 4-9-р сард буюу дулаан улиралд жилд унах нийт хур тунадасны 85%, 10-03-р сард өөрөө хэлбэл хүйтний улиралд 10.4 орчим хувь байна.

4.4. Салхи, шуурга

Заамар сумын салхины дундаж хурд, жилийн явц, их салхитай өдрийн тоо, шороон шуургатай өдрийн тоог олон жилийн дундажтай харьцуулж Заамар сумын их салхитай өдрийн тоо ОЖД-тай харьцуулахад сүүлийн жилүүдэд хүчтэй салхитай өдрийн тоо зарим жилд 2-р сараас бусад бүх сард 1 бус удаа ажиглагдсан нь харагдаж байна.



Зураг 11. Салхины дундаж хурдны жилийн явц



Зураг 12. Заамар сумын нутаг дах шороон шуургатай өдрийн тоо

Заамар сумын шороон шуурганы жилийн явц болон олон жилийн дундажтай харьцуулсан. Төв аймгийн болон Монгол орны нутаг дээр ажиглагддаг шороон шуурганы жилийн явцтай адилхан хаврын улиралд хамгийн их, намрын улиралд нилээд их давтагдалтай байна. Шороон шуургатай өдрийн тоог ОЖД-тай харьцуулж үзвэл сүүлийн жилүүдээс зарим жилийн 10 ба 11-р сард 1 бус удаа ажиглагдсан нь харагдаж байна. Салхи голдуу хойт ба баруун хойт чиглэлтэй байх ба салхины жилийн дундаж хурд нь 3.5 м/сек бөгөөд 3-4-р саруудад салхины хурд 20 м/сек хүртэл хүрдэг. Салхины дундаж хурд нийт нутгаар 0.1-4.6 м/с байснаас Батсүмбэр суманд 0.1 м/с (02 сард), Баянжаргалан суманд 4.6 м/с (02 сард) хүрсэн. Салхины их хурд 10-19 м/с байснаас Баян-Өнжүүл суманд 10 м/с, Зуунмод, Угтаал суманд 01 дүгээр сарын

12, 19-нд 19 м/с хүрч салхилсан. 10 м/с-ээс дээш хурдтай өдрийн тоо нийт нутгаар 2-16 өдөр байснаас Мөнгөнморьт, Алтанбулаг, Жаргалант суманд 2 өдөр, Баянжаргалан суманд 16 өдөр байв. 15 м/с-ээс дээш хурдтай өдрийн тоо 12 дугаар сард Зуунмод, Баян, Бүрэн, Эрдэнэ, Дэлгэрхаан суманд 1 өдөр, 01 дүгээр сард Зуунмод, Угтаал, Алтанбулаг, Жаргалант суманд 1-3 өдөр, сумдын нутгаар ажиглагдаагүй, харин 02 дугаар сард Зуунмод, Угтаал, Баянжаргалан суманд 1-2 өдөр, бусад сумдын нутгаар 15 м/с-ээс дээш хурдтай өдөр ажиглагдаагүй байна. Өвлийн улиралд орон шуургатай өдрийн тоо 27, намын цасан шуургатай өдрийн тоо 8, явган цасан шуургатай өдрийн тоо 94 өдөр ажиглагдсан байна.

5. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2022 онд хийгдэх цохилтот өрөмдлөгийн ажлын үед дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах утаа тортог агаар орчинд хэсэгчилсэн бохирдолтыг бий болгох эрсдэлтэй бөгөөд хайгуулын ажлын явцад агаарт тоосжилт үүсэх.

Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Түлш шатахуун, шатах тослох материалууд асгарах зэргээс үүдэн газрын болон газрын доорх ус бохирдох эрсдэлтэй. Ахуйн хатуу болон шингэн хог хаягдлын асуудлаа зөв менежментын дагуу явуулаагүйгээс болж газрын гадарга болон гүний ус биологийн болон химийн бохирдолд орох эрсдэлтэй учир технологийн горимийг чанд мөрдөж ажиллах шаардлагатай.

Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2022 оны хайгуулын ажлаар өрөмдлөгийн ажил хийгдэх үед газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч доройтож, ургамлан нөмрөг хөрсөнд дарагдах зэргээр өөрчлөлт орох магадлалтай.

Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлан нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг болж бүрхэц багасана. Газрын гадарга болон хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдож болзошгүй.

Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтдууд дайжиж алга болох, мөн хөрс хуулалтын үйл ажиллагаанаас хөрсөн дэх макро, микро бичил амьтад үхэж хорогдох зэрэг нөлөөллүүд үүсч болно.

6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ХҮРЭЭНД СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭГ АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН НЬ

6.1. Агаар орчныг сөрөг нөлөөлөлийг бууруулах арга хэмжээний биелэлт

“Цүй Ханг Инвест” ХХК-ийн MV-012325 дугаарт тусгай зөвшөөрөл бүхий Бэрх-Уул нэртэй алтны үндсэн ордын олборлолтын явцад тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн дутуу шаталтаас үүсэх хийн хаягдал, олборлолт, төслийн талбайн орчны элэгдэж эвдэрсэн талбайгаас механик нөлөөгөөр үүсэх тоосжилт зэрэг нь орчны агаарын чанарыг илэрхийлнэ. Иймд төслийн талбайн орчны агаарын чанарын өнөөгийн байдлыг тодорхойлох зорилгоор агаар дахь бохирдуулагч бодисуудыг агууламжийн хэмжилт судалгааны мэдээллийг үндэслэн тооцсон.

Хэмжилтийн төрөл

1. O₂- Хүчилтөрөгч
2. H₂S-Устөрөгчийн сульфид
3. CO-Нүүрстөрөгчийн дутуу исэл
4. PM1.0-Тоосонцор
5. PM2.5-Тоосонцор
6. PM10-Тоосонцор
7. TSP-Нийт тоос
8. Temperature-Агаарын температур
9. Humidity-Чийгшил
10. AQI-Агаарын чанар

Хүснэгт 2. Агаарын хэмжилтийн төрөл

№	Сорьц авсан цэг	O ₂ %	H ₂ S ppm	CO ppm	PM1.0 ug/m ³	PM2.5 ug/m ³	PM10 ug/m ³	Temp °C	Hum %	AQI
1	Ил уурхайн ойролцоо	20.9	0	0	9	15	19	18.9	75	Маш сайн
2	Отваль	20.9	0	0	9	16	20	20.7	67	Маш сайн

Төслийн талбай орчмын хүхэрлэг хий, азотын давхар исэлийн хэмжээ, нийт тоосны үзүүлэлт нь “Агаарын чанарын MNS 4585:2016 стандарт”-ыг хангаж байна.

Агаарын бохирдол гэж хүрээлэн байгаа агаарт шууд хаягдсан, эсхүл физик, химийн урвалын дүнд шинээр үүсч бий болсон бохирдуулах бодисын агууламж нь агаарын чанарын стандартаас хэтрэхийг хэлнэ.

6.2. Усан орчны сөрөг нөлөөлөлийг бууруулах арга хэмжээний биелэлт

“Бэрх-Уул” алтны үндсэн ордын талбай нь ус зүйн сүлжээний хувьд Туул галын ай сав газарт хамаардаг уурхайн усны хэрэгцээг гүний худгаас хангадаг.

Усны мониторингийн гол зорилго нь “Бэрх-Уул” алтны үндсэн ордын уурхайн ажилчдын ундны усны чанар болон тухайн орон нутгийн гүний усны шинж чанарын ерөнхий үзүүлэлтүүдийг тодорхойлж ундны усны стандартыг хангаж байгаа эсэхийг тодорхойлоход оршино. Усны

мониторингийн ажлыг уурхайн худгаас мониторингийн дээжлэлт авч ШУА Газарзүй-геоэкологийн хүрээлэнгийн усны шинжилгээний лабораторид өгч шинжлүүлсэн болно.

“Их Зос” ХХК-ийн мэргэжилтнүүд 2023 оны 06 сарын 23-нд төслийн талбайн гүний худгийн уснаас дээж авч ШУА-ийн “Геоэкологийн хүрээлэн”-ийн усны шинжилгээний лабораторид өгч шинжлүүлсэн.

Сорьц авсан газрын нэр: Төв аймаг, Заамар сум “Цүй Ханг Инвест” ХХК

Уст цэгийн төрөл: Гүний худаг

Дүгнэлт: Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, холимог бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөвтөр ус байна. Шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүд нь “Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018” стандартын шаардлага хангаж байна.

Хүснэгт 3. Усны шинжилгээний дүн

Нэршил	Анион	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ	1 дм ³ -д байгаа						Катион	1 дм ³ -д байгаа					
			Мг (2023 болон 2022 оны харьцуулалт)		Мг-экв (2023 болон 2022 оны харьцуулалт)		Мг-экв % (2023 болон 2022 оны харьцуулалт)			Мг (2023 болон 2022 оны харьцуулалт)		Мг-экв (2023 болон 2022 оны харьцуулалт)		Мг-экв % (2023 болон 2022 оны харьцуулалт)	
Хлорид	Cl ⁻	<350.0	25.6	38.3	0.72	1.08	10.6	16.0	Na ⁺ K ⁺	45.1	80.0	1.96	3.48	28.8	51.4
Сульфат	SO ₄ ⁻	<500	96.0	90.0	2.00	1.88	29.4	27.7	Ca ⁺⁺	53.9	53.3	53.9	2.66	39.5	39.3
Нитрит	NO ₂ ⁻	<1.000	0.0	0.0	0.00	0.00	0.00	0.00	Mg ⁺⁺	26.1	7.4	26.1	0.61	31.6	9.0
Нитрат	NO ₃ ⁻	<50.0	11.5	0.8	0.19	0.01	2.7	0.2	NH ₄ ⁺	0.1	0.1	0.1	0.01	0.1	0.1
Карбонат	CO ₃ ⁻	-	0.0	0.0	0.00	0.00	0.00	0.00	Fe ⁺⁺	0.0	0.0	0.00	0.00	0.0	0.0
Гидрокарбонат	HCO ₃ ⁻	-	237.9	231.8	3.90	3.80	57.3	56.1	Fe ⁺⁺⁺	0.0	0.3	0.00	0.02	0.0	0.2
Дүн		-	371.0	360.9	6.81	6.77	100.0	100.0	Дүн	125.2	141.1	125.2	6.77	100.0	100.0

Шинжилсэн үзүүлэлт	Нэгж	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ	Худаг
Ерөнхий хатуулаг	Мг-экв/дм ³	7.0	4.84
Урвалын орчин	pH	6.5-8.5	6.76
ЦДЧ ЕС	dS/m	-	598
Үнэр	Оноо	<2.0	0
Өнгө	Градус	<20.0	Үгүй
Амт	Оноо	<2.0	***
Тунгалаг	См	-	30 см
Тунадас	-	-	Үгүй
Исэлдэх чанар	Мг/дм ³	-	3.20

6.3. Ургамлан орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Ургамлын орчны сөрөг нөлөөлөлийг бууруулах зорилгоор дараах арга хэмжээг авсан. Ургамалжилтын мониторингийн хээрийн судалгааг 2023 оны 06 дугаар сарын 23-нд хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Судалгааны зорилго: Уурхайн үйл ажиллагааны явцад ургамлан бүрхэвчийн өөрчлөлт, доройтол ажиглагдаж байгаа эсэх, мөн уурхайн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлоход ургамлын мониторингийн судалгааны зорилго оршино.

Судалгааны арга зүй: Мониторингийн ажлын хүрээнд хяналт шинжилгээний тогтоосон цэг тус бүрд ургамлын бичиглэл хийн, зүйлийн бүрдлийг тодорхойлон, өөрчлөлт доройтлыг тогтоож, биомассын хэмжилтийг хийсэн. Геоботаникийн бичиглэл хийхийн тулд тухай газарт 10x10 м², 1x1 м² раменскийн тор татаж тус талбайд зүйл тус бүрээр нь бичиглэл хийж, хээрийн судалгааны мэдээ материал цуглуулан боловсруулалт хийсэн.

ГЕОБОТАНИКИЙН БИЧИГЛЭЛД:

Зүйлийн бүрэлдэхүүн: Ургамал бүлгэмдэл бүрт ургасан ургамлын нийт зүйлийг хээрийн судалгаагаар бүртгэж, фото зургийг авч тодорхойлох боломжгүй зүйлийг бичиглэлийн хуудсанд кодлон бичээд, тус зүйлийн хатаамал хийж, лабораторид тодорхойлсны дараа нэрийг нь бичсэн. Ургамал тодорхойлохдоо И.В. Грубов (2008), Н. Өлзийхутаг (1985), болон бусад (Flora of China, 2019) эх сурвалжийг ашиглав. Ургамлын зүйлийг “Монгол орны биологийн олон янз байдал: ургамал, мөөг, бичил биетний зүйлийн жагсаалт”-нд зааснаар (Ургамал нар, 2019) нэрлэсэн.


Арви: Бүлгэмдлийн зүйлийн арвид О. Друдегийн нүдэн баримжааны аргаар үнэлгээг өгсөн.

Тусгаг бүрхэц: Тусгагийн бүрхэц (цаашид бүрхэц хэмээв) нь аливаа биетийн газрын гадаргуу дээрх тусгалын проекц юм. Бүлгэмдлийн нийт бүрхэц, халцгай газар, хагд болон зүйл тус бүрийн бүрхэцийг 1м x 1м хэмжээтэй тор ашиглан хувиар үнэлж, гэрэл зургаар баталгаажуулав.

Өсөлт: Ургамлан өсөлтийг тодорхойлохын тулд өндрийг сантиметрийн хэмжээст шугамаар газрын хөрснөөс дээш 0 см-ийн өндөрт хэмжсэн.


Ургац тодорхойлох арга: Зүйлийн бүрэлдэхүүн цөөн, ургамалжил шигүү биш байхад 1 м² хэмжээгээс дээж авах тохиромжтой (Түвшинтогтох, 2005). Ургамлыг зүйл тус бүрээр газрын гадаргын түвшинд хайчлан авч, цаасан уутанд хийнэ. Хээрээс цуглуулсан дээжээ тасалгааны температурт 2-3 долоо хоног хатаана. Харьцангуй хуурай жинг 0.01-0.05 гр-ын нарийвчлалтай электрон жингээр тодорхойлно.

6.3.1. Ургамалжилтын онцлог, өнөөгийн төлөв байдал



Зураг 13. Монгол орны ургамал газарзүйн тойрог

Төслийн талбай нь Монгол орны ургамал газарзүйн тойргийн ангиллаар Монгол дагуурын хээрийн тойрогт хамаарна. Тус тойрогт ой, уулархаг хээрийн ургамал зонхилох бөгөөд зөвхөн энэ тойрогт тохиолдох 33 зүйл ургамал тэмдэглэгджээ. Үүнд: Даагансүүл, Биелэг өвс, Улалж, Хус, Тарна, Тооронцор, Гичгэнэ, Харгана, Ортууз, Ноной, Банздоо, Хөхтолгой, Чирэг, Харцгана, Могодоохой, Зэгс, Цахирам, Хорголжин, Туурам, Хошоонгор, Цэгцүүхэй, Чөдөр өвс, Халгацай, Шагшуурга, Харуу цэцэг, Салжир, Зохимон, Гандбадраа, Шарилж, Азаргана, Банга зэрэг төрөлд хамаарах зүйлүүд орно.



Зураг 14. Төслийн талбайн ургамалжилтын хэв шинжийн тархалт

Биелэг алаг өвс ба биелэг-улалж-алаг өвст бүлгэмдэл болон Хялгана алаг өвст бүлгэмдэл тархсан байна. Төслийн талбай болон бичиглэл хийсэн цэгийн ойролцоо Улалж-үетэн алаг өвст бүлгэмдэл тархсан байна.

6.3.2. Ургамлын бичиглэл №01 “Биелэг алаг өвс ба биелэг-улалж-алаг өвст бүлгэмдэл”
Ургамлан бүрхэвч: 47.1%

Газрын гадаргуу: Уулын энгэр, жалгын хажуу

Фенологи: Ургал үе

Хүн мал амьтны нөлөө: 5

Усан хангамж: Хур тунадас

Өргөрөг: 48°32'24.6" N

Уртраг: 104°36'29.1" E

Зонхилох ургамлууд: Биелэг алаг өвс ба биелэг-улалж-алаг өвст бүлгэмдлийн нэгж талбайд 15 зүйл ургамал бичиглэл хийх явцад тэмдэглэгдсэн бөгөөд *Artemisia sieversiana* (Сиверсийн шарилж) 15%, *Carex duruiscula* (Ширэг улалж) 10%, *Carum carvi* (Эгэл гоньд) 8.5%, *Artemisia scoparia* (Шүүрэн шарилж) 7.1% зонхилж, дэд зонхилогчоор *Agropyron cristatum* (Саман ерхөг) 3.5%, *Heteropappus hispidus* (Арзгар согсоолж) 3%, бүртгэгдэв. Мөн хагд өвс 36.9%, нүцгэн хөрс 15.5%, чулуу 0.5%-ийг эзэлж байв.

Ургамлын дундаж өндөр: 10-12 см



Зураг 15. Т-1 Ил уурхайн карьер орчмын ургамлын бичиглэл

Дэд зонхилох ургамлууд: Биелэг алаг өвс ба биелэг-улалж-алаг өвст бүлгэмдлийн нэгж талбарт 10 м² талбайд *Cleistogenes squarrosa* (Дэрвээн хазааргана), *Potentilla bifurca* (Имт гичгэнэ), *Koeleria macrantha* (Том цэцэгт дурваа) зэрэг зүйл ургамал ургасан байв.

Ургамлын арвийн үнэлгээний хувьд зонхилогч ургамлууд нь Sor3, бусад зүйл ургамлууд нь Sp, цөөн хэдэн зүйл ургамал нь Sol үнэлгээтэй байна. Уг бүлгэмдэл нь антропоген болон техникийн нөлөөлөлд өртсөн төлөв байдалтай байна.

Ургамлын биомасс: Ургамлан бүрхэвчийн нийт биомасс-12.44 ц/га

6.3.3. Ургамлын бичиглэл №02 “Улалж-үетэн алаг өвст бүлгэмдэл”

Ургамлан бүрхэвч: 52%

Газрын гадаргуу: Жалгын хажуу

Фенологи: Ургал үе

Хүн мал амьтны нөлөө: 2

Усан хангамж: Хур тунадас

Өргөрөг: 48°32'20.3" N

Уртраг: 104°36'16.5" E

Зонхилох ургамлууд: Улалж-үетэн алаг өвст бүлгэмдлийн нэгж талбайд 11 зүйл ургамал *Carex duriuscula* (Ширэг өлөн) 30.6%, *Artemisia adamsii* (Адамсын шарилж) 9.5%, *Artemisia frigida* (Агь, Өлчир шарилж) 4.5 %, *Agropyron cristatum* (Саман ерхөг) 4.5%, дэд зонхилогчоор *Cleistogenes squarrosa* (Дэрвээн хазааргана) 0.9, *Heteropappus hispidus* (Арзгар согсоолж) 0.2%, зонхилж, , *Iris tigridia* (Бар цоохор цахилдаг) 1.2%, бүртгэгдэв. Мөн хагд өвс 43.3%, нүцгэн хөрс 4.5%, баас 0.2%-ийг эзэлж байв.



Зураг 16. Т-2 Отваль орчмын ургамлын бичиглэл

Ургамлын дундаж өндөр: 7-9 см

Дэд зонхилох ургамлууд: Улалж-үетэн алаг өвст бүлгэмдэл нэгж талбарт 10 м² талбайд *Iris tigridia* (Бар цоохор цахилдаг), *Astragalus brevifolius* (Ахар навчит хунчир) зэрэг зүйлүүд тархсан. Тус зүйлүүдийн дундаж өндөр нь 12 см, доройтлын зэрэг сул доройтсон ангилалд багтаж байна.

Ургамлын биомасс: Ургамлан бүрхэвчийн нийт биомасс-10.36 ц/га

Хүснэгт 4. Төслийн талбайд зонхилон тааралдах ургамлын зүйлийн жагсаалт

д/д	Латин нэр	Монгол нэр	Арви	Өндөр /см/
I. Poaceae Barnhart - Үетний овог				
1	<i>Agropyron cristatum</i> (L.) Gaertner 1770	Саман ерхөг	Sol	4.9
2	<i>Cleistogenes squarrosa</i> (Trin.) Keng 1934	Дэрвээн хазааргана	Sp	8
3	<i>Koeleria macrantha</i> (Ledeb.) Schult. 1824	Том цэцэгт дурваа	Sp	12
II. – Rosaceae Juss - Сарнайн овог				
4	<i>Potentilla bifurca</i> L. 1753	Имт гичгэнэ	Sol	5.3
5	<i>Potentilla acaulis</i> L. 1753	Ишгүй гичгэнэ	Cop2	1.8
6	<i>Potentilla viscosa</i>	Наалданги гичгэнэ	Sol	4.1
III. Asteraceae Bercht.& J.Presl – Гол гэсэрийн овог (Нийлмэл цэцэгтэн)				
7	<i>Heteropappus hispidus</i>	Арзгар согсоолж	Sol	7
8	<i>Artemisia frigida</i> Willd. 1803	Агь, Өлчир шарилж	Sol	6.8
9	<i>Artemisia adamsii</i> Besser 1834	Адамсын шарилж	Sp	3
10	<i>Artemisia scoparia</i> Waldst. & Kitam. 1802	Шүүрэн шарилж	Sol	4.5
11	<i>Artemisia sieversiana</i> Willd. 1803	Сиверсийн шарилж	Cop2	21
IV. Cyperaceae Juss. 1789 -Улалжтаны овог				
12	<i>Carex duriuscula</i> C.A. Mey. 1831	Ширэг өлөн	Cop3	8.6
V. Asteraceae- Гол гэсэртэний овог				
13	<i>Taraxacum officinale</i> F.H. Wigg. 1780	Эмийн багваахай	Sol	7.5
VI. Apiaceae-Шүхэртэн				
14	<i>Carum carvi</i> L. 1753	Эгэл гоньд	Sol	6.8
VII. Ephedraceae- Зээргэний овог				
15	<i>Ephedra sinica</i> Stapf 1927	Нангиад зээргэнэ	Sol	5.9
VIII. Iridaceae- Цахилдагийн овог				
16	<i>Iris tigridia</i> Bunge ex Ledeb. 1829	Бар цоохор цахилдаг	Sol	13
IX. Fabaceae Lindl. 1836 - Буурцагтны овог				
17	<i>Astragalus brevifolius</i> Ledeb. 1831	Ахар навчит хунчир	Sp	5

6.4. Хөрсөн бүрхэвчийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

2023 оны 06-р сарын 23-ны өдөр мониторингийн цэгүүдээс хөрсний 2 ш зүсэлт хийж, хөрсний морфологи бичиглэлийг хээрийн нөхцөлд тодорхойлж, хөрсний үе давхарга бүрээс лабораторийн задлан шинжилгээнд зориулан 4 ш дээж авсан.

Лабораторийн задлан шинжилгээ: Хөрсөн бүрхэвчийн судалгааг хийхдээ төслийн талбайн мониторинг цэгүүдээс авсан дээжийг ШУА, Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн итгэмжлэгдсэн хөрс судлалын лабораторид дараах үзүүлэлтүүдийг тодорхойлуулсан.

Хүснэгт 5. Хөрсний дээжид задлан шинжилгээ хийсэн арга, нарийвчлал

Үзүүлэлт	Аргазүй	Стандарт
Дээж бэлтгэх, хатаах	Хуурай аргын нөхцөлд	ISO11464:2006 Soil quality-Pretreatment of samples for physical- chemical analysis
Дээж шигших	2 мм	
pH	Хөрс:ус (1:2.5), pHметр	pH-ыг тодорхойлох MNS ISO 10390-2001
CaCO ₃	Кальциметр, эзэлхүүний	Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох арга, MNS 3310:1991
Цахилгаан дамжуулах чадвар	Хөрс:ус (1:2.5), ЕС метр	
Органикийн агууламж	Тюрины, Бихроматын исэлдэлт	
Хөдөлгөөнт Фосфор, Кали	Мачигины арга	
Механик бүрэлдэхүүн (элс 2-0.05мм, тоос 0.05-0.002 мм, шавар <0.002 мм)	Пипеткийн арга	ISO11277:2009 Soil quality-Determination of particle size distribution in mineral soil material- Method by sieving and sedimentation

6.4.1. Хөрсний зүсэлтийн бичиглэл №01

Хөрсний дээж авсан цэгийн газарзүйнбайршил:

Өргөрөг: 48°32'33.05" N

Уртраг: 104°36'38.02" E

Гадаргын мэдээлэл Гадарга:

Уулын бэл хажуу **Бичил гадарга:**

Налуу

Гадаргын налуу: 8-10°

Зүг зовхис: Зүүн хойд

Хөрсний эвдрэл: Уурхайн олборлолтыннөлөөгөөр ойр орчмын хөрсний гадарга нь эвдрэлд орсон

Гадаргын бичиглэл: Карбонаттай хархүрэн хөрс

Гадаргын чулуу: Чулуурхаг

Ургамлын бүрхэц: 60-65%



Хөрсний морфологи шинж чанар

А 0-20: Хар хүрэн, өлөн чийгтэй, хөнгөн шавранцар, бөөмөрхөг, маш нягт, ургамлын нарийн үндэс дунд зэрэг

В 20-40: Цайвар хүрэн, бага зэрэг чийгтэй, хөнгөн шавранцар, бөөмөрхөг үрлэн бүтэцтэй, дунд зэрэг нягттай, жижиг хэмжээтэй хэмхдэс чулуу 5-10%




Хүснэгт 6. Хөрсний химийн шинж чанар

Зүсэлтийн дугаар	Гүн, см	Ph (1:5)	CaC O ₃ %	Ялзмаг %	EC ₅ Ds/m	Шим тэжээлийн элементүүд мг/100гр	
						P ₂ O ₅	K ₂ O
Зүсэлт 1	0-20	8.12	0.73	3.211	0.122	1.69	3.30
	20-40	8.46	7.27	1.119	0.154	0.91	0.65



Хүснэгт 7. Хөрсний механик бүрэлдэхүүн

Дээжний дугаар	Үе давхарга	Гүн, см	Ширхэгийн хэмжээ, % (мм-ээр)		
			Элс (2-0.05мм)	Тоос (0.05-0.002мм)	Шавар (<0.002мм)
Зүсэлт 1	А үе	0-20	71.7	18.7	9.6
	В үе	20-40	74.6	17.6	7.9



Хөрсний зүсэлт 1 дээж нь шүлтлэг урвалын орчинтой, А үе бага зэрэг, В үе дунд зэрэг карбонатлаг, ялмагийн агууламжаар А үе нь дунд зэрэг, В үе нь бага зэрэг, цахилгаан дамжуулах чанараар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфорын хангамжаар В үе бага зэрэг, А үе дунд зэрэг, хөдөлгөөнт калийн хангамжаар бага зэрэг, механик бүрэлдэхүүн элсэнцэр, хөрсний үржил шимийн ерөний түвшин бага.




Зураг 17. Хөрсний зүсэл-1



2021-2023 оны хооронд талбайд тархсан хөрсний шимт үе давхарга буюу дээж авсан А үе 15-25 см-т урвалын орчин (pH1:2.5) нь дунджаар 7.78 саармаг орчинтой, ерөнхий хандлага тогтвортой ($y=0.295x+7.1933$; $R^2=0.5364$). Ялзмагийн бодисын агууламж дунджаар 3.4% буюу дундаж агууламжтай бөгөөд өсөх хандлагатай. ($y=0.7765x+1.8467$; $R^2=0.8868$).




Хөрсөн дэхь нийт хялбар уусах давсжилт буюу хөрсний цахилгаан дамжуулах чанар (EC) нь дунджаар 0.08 dS/m давсжилтгүй, судалгааны жилүүдийн хооронд өөрчлөлтгүй ($y=0.029x+0.0233$; $R^2=0.2296$). Хөрсний үржил шимийн үзүүлэлт болох хөдөлгөөнт фосфор / P_2O_5 дунджаар 2.15 мг дунд зэрэг, өөрчлөлтгүй. ($y=-0.11x+2.3733$; $R^2=0.0371$).



Хөдөлгөөнт калийн хангамжаар 2012-2023 оны хугацаанд дунджаар 21.07, жилүүдийн хооронд статистик ялгаатай ч өөрчлөлтгүй ($y = -5.09x + 31.253$; $R^2 = 0.5873$). Механик бүрэлдэхүүн болох элсний агууламж дунджаар 45.5, судалгааны жилүүдэд өсөх хандлагатай ($y = 14.65x + 16.233$; $R^2 = 0.694$), тоосны агууламж дунджаар 31.03, буурах хандлагатай ($y = -12.8x + 56.633$; $R^2 = 0.6717$), шаврын агууламж дунджаар 14.17, жилүүдийн хооронд тогтвортой ($y = -1.8x + 17.767$; $R^2 = 0.3056$).

6.4.2. Хөрсний зүсэлтийн бичиглэл №02

<p>Хөрсний дээж авсан цэгийн газарзүйн байршил: Өргөрөг: 48°32'26.62" N Уртраг: 104°36'7.95" E Гадаргын мэдээлэл Гадарга: Уулын хоорондын тэгшивтэр хөндий Бичил гадарга: Тэгшивтэр Гадаргын налуу: 3-5° Зүг зовхис: Баруун Хөрсний эвдрэл: Эвдрэлд өртөөгүй Гадаргын бичиглэл Гадаргын чулуу: Чулуугүй Ургамлын бүрхэц: 50-55%</p>	
--	--



Хүснэгт 8. Хөрсний химийн шинж чанар


Зүсэлтийн дугаар	Гүн, см	Ph (1:5)	CaCO ₃ %	Ялзмаг %	EC ₅ Ds/m	Шим тэжээлийн элементүүд мг/100гр	
						P ₂ O ₅	K ₂ O
Зүсэлт 1	0-20	7.92	0.00	4.016	0.141	1.72	13.52
	20-40	8.39	3.64	1.497	0.132	1.65	4.06

Хүснэгт 9. Хөрсний механик бүрэлдэхүүн


Дээжний дугаар	Үе давхарга	Гүн, см	Ширхэгийн хэмжээ, % (мм-ээр)		
			Элс (2-0.05мм)	Тоос (0.05-0.002мм)	Шавар (<0.002мм)
Зүсэлт 1	А үе	0-20	65.8	23.4	10.8
	В үе	20-40	70.2	19.8	10.1

Хөрсний зүсэлт 2 дээжний А үе нь сул шүлтлэг, В үе нь шүлтлэг урвалын орчинтой, А үе карбонатгүй, В үе дунд зэрэг карбонатлаг, ялзмагийн агууламжаар А үе дунд зэрэг, В үе бага зэрэг, цахилгаан дамжуулах чанараар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфорын


хангамжаар А болон В үе дунд зэрэг, хөдөлгөөнт калийн хангамжаар бага зэрэг, механик бүрэлдэхүүн элсэнцэр, хөрсний үржил шимийн ерөнхий түвшин дундаж.




Зураг 18. Хөрсний зүсэлт-2



2021-2023 оны хооронд талбайд тархсан хөрсний шимт үе давхарга буюу дээж авсан А үе 15-25 см-т урвалын орчин (pH1:2.5) нь дунджаар 7.78 саармаг орчинтой, ерөнхий хандлага тогтвортой ($y=0.295x+7.1933$; $R^2=0.5364$). Ялзмагийн бодисын агууламж дунджаар 3.4% буюу дундаж агууламжтай бөгөөд өсөх хандлагатай. ($y=0.7765x+1.8467$; $R^2=0.8868$).



Хөрсөн дэх нийт хялбар уусах давжилт буюу хөрсний цахилгаан дамжуулах чанар (ЕС) нь дунджаар 0.08 dS/m давжилтгүй, судалгааны жилүүдийн хооронд өөрчлөлтгүй ($y=0.029x+0.0233$; $R^2=0.2296$). Хөрсний үржил шимийн үзүүлэлт болох хөдөлгөөнт фосфор / P_2O_5 / дунджаар 2.15 мг дунд зэрэг, өөрчлөлтгүй. ($y=-0.11x+2.3733$; $R^2=0.0371$).



Хөдөлгөөнт калийн хангамжаар 2021-2023 оны хугацаанд дунджаар 21.07, жилүүдийн хооронд статистик ялгаатай ч өөрчлөлтгүй ($y=-5.09x+31.253$; $R^2=0.5873$). Механик бүрэлдэхүүн болох элсний агууламж дунджаар 45.5, судалгааны жилүүдэд өсөх хандлагатай ($y=14.65x+16.233$; $R^2=0.694$), тоосны агууламж дунджаар 31.03, буурах хандлагатай ($y=-12.8x+56.633$; $R^2=0.6717$), шаврын агууламж дунджаар 14.17, жилүүдийн хооронд тогтвортой ($y=-1.8x+17.767$; $R^2=0.3056$).

6.4.3. Хөрсөн дэхь хүнд металлын шинжилгээний дүн

Хөрсөн дэхь хүнд металлын судалгааг хийхдээ төслийн талбайн мониторинг цэгүүдээс авсан дээжийг “Алс” ХХК итгэмжлэгдсэн хөрс судлалын лабораторид дараах үзүүлэлтүүдийг тодорхойлуулсан.

Хүснэгт 10. Хөрсөн дэхь хүнд металлын агууламж

Дээжийндугаар	Хүнд металлын агууламж							
	Элемент %							
	Al	Ca	Fe	K	Mg	Na	S	Ti
Ил уурхай	7.39	5.05	4.67	1.44	2.05	1.72	0.05	0.52
Отваль	7.76	2.63	4.64	1.9	1.71	1.9	0.04	0.54
Хүлцэх агууламж MNS5850:2019	-	-	-	-	-	-	-	-
Хортой агууламж MNS5850:2019	-	-	-	-	-	-	-	-
Аюултай агууламж MNS5850:2019	-	-	-	-	-	-	-	-

Дээжийндугаар	Хүнд металлын агууламж									
	Элемент мг/кг									
	Ag	As	Ba	Be	Bi	Cd	Co	Cr	Cu	
Ил уурхай	<0.5	8	450	1.6	<2	<0.5	21	86	39	
Отваль	<0.5	<5	590	1.7	3	<0.5	20	66	35	
Хүлцэх агууламж MNS5850:2019	-	20.00	-	-	-	3.00	50.00	150.0	100.0	
Хортой агууламж MNS5850:2019	-	50	-	-	-	10	500	400	500	
Аюултай агууламж MNS5850:2019	-	100	-	-	-	20	1000	1500	1000	
Дээжийндугаар	Хүнд металлын агууламж									
	Элемент мг/кг									
	Ga	La	Li	Mn	Mo	Ni	P	Pb	Sb	
Ил уурхай	10	30	30	806	<1	43	990	13	<5	
Отваль	20	30	30	966	1	31	910	15	<5	
Хүлцэх агууламж MNS5850:2019	-	-	-	-	5.0	150.0	-	100.0	-	
Хортой агууламж MNS5850:2019	-	-	-	-	20	1000	-	500	-	
Аюултай агууламж MNS5850:2019	-	-	-	-	50	1800	-	1200	-	

Дээжийн дугаар	Хүнд металлын агууламж								
	Элемент мг/кг								
	Sc	Sr	Th	Tl	U	V	W	Zn	**
Ил уурхай	17	332	<20	<10	<10	123	<10	83	**
Отваль	16	346	<20	<10	<10	116	<10	92	**
Хүлцэх агууламж MNS5850:2019	10.00	800.0	-	-	-	150.0	-	300.0	
Хортой агууламж MNS5850:2019	50	3000	-	-	-	600	-	600	
Аюултай агууламж MNS5850:2019	100	6000	-	-	-	1000	-	1000	

Ил уурхайн, отвалиас авсан дээжинд хүнд металлын агууламжийг “Алс” ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторит тодорхойлуулсан ба MNS5850:2019 стандарттай харьцуулахад хүнд металлын бохирдолгүй байна.

7. ДҮЙЦҮҮЛЭН НӨХӨН СЭРГЭЭЛТ БОЛОН ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.6, 9 дүгээр зүйл 9.6-д дүйцүүлэн хамгааллыг хэрэгжүүлэх талаар заасны дагуу Төв аймгийн байгаль орчны газраас 3 га газар техникийн нөхөн сэргээлт хийх талбайг өгсөн. Төв аймгийн Заамар сумын нутагт нийт 3 га 70 сот газар техникийн нөхөн сэргээлтийг хийж Заамар сумын байгаль орчны мэргэжилтэн, Төв аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газрын байгаль орчны ахлах мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.



Зураг 19. Техникийн нөхөн сэргээлт хийхийн өмнө-1




Зураг 20. Техникийн нөхөн сэргээлт хийхийн өмнө-2




Зураг 21. Техникийн нөхөн сэргээлт хийхийн өмнө-3




Зураг 22. Техникийн нөхөн сэргээлт хийж буй явц



Зураг 23. Техникийн нөхөн сэргээлт хийсэний дараа-1



Зураг 24. Техникийн нөхөн сэргээлт хийсний дараа-2



Зураг 25. Техникийн нөхөн сэргээлт хийсний дараа-3

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн ашиглалтын талбайн ойр орчмын айл өрх, өвөлжөө хаваржааны газрыг нүүлгэн шилжүүлэх ажил хийгдэхгүй болно.

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уулын ажил явагдах үед уурхайн малталтанд орох эдэлбэрийн нийт талбайд ажиглалт явуулж түүх дурсгалын зүйлс, булш хиргэсүүр байж болзошгүй ямар нэгэн зүйлс шинээр илэрээгүй болно.

10. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Манай компани хүдэр боловсруулах үйлдвэр байхгүй бөгөөд олборлосон хүдрийг “Тэн Хун” ХХК-ын баяжуулах үйлдвэрт боловсруулахаар худалдаалдаг болно. Иймд өрөмдлөг тэсэлгээний ажлын үед химийн бодис ашиглахгүй. Тиймээс химийн бодисын менежментийн төлөвлөгөө хийгдэх шаардлагагүй гэж үзэж байна.

11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Өдөр тутмын уурхайн хотхон орчмын хог хаягдал болон ажилчдын ахуйн хэрэглээнээс гарч хог хаягдлыг хашаалж хамгаалсан тогтсон хогийн цэгт хаяж булж устгаж байхаар Заамар сумын засаг даргатай хамтын гэрээг байгуулж хог хаягдал үүсгэгчийн төлбөрийг төлсөн. Ашиглалтын талбай орчим.

Тос тослох материалын хог хаягдал болон тээврийн компанийн машин тоног төхөөрөмжөөс тос тослох материал арчсан хог хаягдал гарч болох тул тус гарах хог хаягдлыг тээврийн компани хариуцан устгах арга хэмжээг авч ажилладаг. Ямар нэгэн байдлаар тос масло асгарсан тохиолдолд бохирдсон хөрсийг ухааж аван төмөр саванд хийж ариутгаж тухайн хэсэг газарт шинэ хөрс хийж тос тослох материал асгахгүй байх талын мэдээлэл сургалтыг ажилчдад анхааруулж өгдөг. Уурхайн хашаалсан талбайн гадуур болон дотуур. Сар бүр зохион байгуулдаг.



Зураг 26. Хөрс хамгаалалт

12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу дараах албан бичиг баримтуудыг бүрдүүлж түүнийхээ дагуу үйл ажиллагаагаа явуулсан.

Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийгдсэн ажлууд	Ажлын гүйцэтгэлийн хэлбэр	Ач холбогдол	Төлөвлөгөөний биелэлт	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах албан тушаалтан
2023 оны байгаль хамгаалах ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Бэрх-Уул уурхайн дарга болон байгаль орчны ажилтан 2023 оны байгал орчныг хамгаалах ажлын төлөвлөгөөг хэрэгжилтийг хянах	2023 онд байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийгдэхээр тусгагдсан ажлуудыг уурхай ажиллах хугацаанд бүрэн хэрэгжүүлэх	Байгаль орчныг хамгаалах гол ажлууд болон техникийн нөхөн сэргээлт, дүйцүүлэх нөхөн сэргээлтийг хийх Заамар сумын байгаль орчны мэргэжилтэн, байгаль орчны байцаагчид хүлээлгэн өгсөн	2023 оны турш	“Цүй Ханг Инвест” ХХК-ийн БОХАБ харицсан дарга
Байгаль орчныг хамгаалах, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалт	Байгаль орчин болоод хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой сургалтыг улирал тутам явагдах сургалтын хөтөлбөрт тусган тогтмол явуулсан.	Нийт ажилчдын байгаль орчныг хамгаалах ХАБ-ын мэдлэгийг дээшлүүлж, уурхайн бүсэд байгаль орчныг хамгаалах тухай болоод ХАБ-ын өдөр тутмын аюулгүй ажиллагааг хэвшил болгох	2023.03.01-нд “Тэн Хун” ХХК-иас зохион байгуулагдсан БО, ХАБ-ийн сургалтанд хамруулсан.	Ажил эхлэх үед	Байгаль орчны мэргэжилтэн, ХАБ-н ажилтан
Газрын гэрээ	Монгол улсын газрын тухай хуульд заагдсаны дагуу орон	Монгол улсын хууль тогтоомжийг	Заамар сумын газрын даамалтай 2023 оны Газар	2023.06.15	Оффис менежер

	нутгийн захиргаатай газрын гэрээг хийж, зохих төлбөрийг хугацаанд нь барагдуулсан	хэрэгжүүлэн ажиллах	ашиглах гэрээг байгуулж үйл ажиллагаа явуулах		
Ус ашиглах дүгнэлт	Монгол улсын усны тухай хуульд заагдсаны дагуу 2023 оны ус ашиглалтын дүгнэлтийг гаргуулсан.	Монгол улсын хууль тогтоомжыг хэрэгжүүлэн ажиллах	Усны тухай хуулийн дагуу ус ашиглах дүгнэлт гаргуулж, усны гэрээг байгуулсан. Дүгнэлтийн дагуу усыг зөв зохистой хэрэглэнэ.	Ус ашиглах дүгнэлт 2023.06.15	
Хаягдал усны гэрээ	Усны газраар хаягдал усны гэрээг байгуулах	Хаягдал усны төлбөрийн тухай хууль тогтоомж	Төлбөрийг төлөх	Хаягдал усны гэрээ 2022.09.14	
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Төслийн талбайн агаар, ургамал, хөрс, уснаас дээж авч лабораторид шинжлүүлэх	Төслийн талбайн байгаль орчны доройтолыг тодорхойлж, бууруулах арга хэмжээ авах	ОХШ-ний боловсруулах	2023.06-р сард	“Их Зос”ХХК

13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ

БОМ орчны хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны төв	Хэлэлцүүлэгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар, байршил
Байгаль орчин аялал жуулчлалын яам Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газар	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт	Тухайн жилд байгаль орчныг хамгаалах, орчны өөрчлөлтийг хянах хөтөлбөр агуулсан байгаль орчны менежментийн тайлан батлуулах	Тухайн жилийн 12 дугаар сард багтаах	БОМТ-нд орсон нутгаас санал авч байгаль орчны төрийн захиргааны төв байгууллагаар хянуулж батлуулах	Орон нутаг, Байгаль орчин Аялал Жуулчлалын яам хугацаандаа тайлагнах
Төв аймгийн байгаль орчны газар	БОМ-ийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан. Төслийн талбай дээр хэрэгжсэн ажлыг тайлагнах	Тухайн жилд байгаль орчныг хамгаалах, орчны өөрчлөлтийг хянах хөтөлбөр агуулсан байгаль орчны менежментийн тайлан батлуулах	Тухайн жилийн 11-р сарын 01-ний дотор	Төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийн дүгнэлт	Төв аймаг БОАЖГазарт хугацаандаа тайлагнах

14. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай сургалтыг хавар болон намар зохион байгуулсан. Хаврын сургалтыг “Тэн Хун” ХХК-аас зохион байгуулж Уул уурхайн үйлдвэрийн тогтвортой, найдвартай ажиллах гол үнэт баялаг бол ажиллагсад, өөрөөр хэлбэл хөдөлмөрийн хүн. Тиймээс ажилчдын эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлд нэн түрүүнд –Хөдөлмөрийн аюулгүй байдал” гэсэн суурь зарчим хэрэгжих явдал юм.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын зорилго нь ажил олгогч, хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтны аюулгүй ажиллах арга барилд сургах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн талаарх мэдлэг олгон, осол эндэгдэлгүй, эрүүл ажиллах соёл, зан үйлийг төлөвшүүлэхэд оршино.

“Цүй Ханг” ХХК нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, ХАБЭА-н сургалт сургалт зохион байгуулах хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх ажлын хүрээнд “Тэн Хун” ХХК-ийн БОХАБЭА-н хэлтэс Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг зохион байгууллаа.

Манай хэлтэс уурхайн үйл ажиллагаа эхэлсэнтэй холбоотойгоор 2023.03.01-ний өдөр Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуй-н нийт ажилчдын сургалтыг зохион байгуулсан.



Зураг 27. Сургалтын үеийн

15. ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУД



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 7/28

Улаанбаатар хот

Техник-эдийн засгийн үндэслэл
хүлээн авах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн т/19-16-03 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-012325 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Цүй Ханг Инвест ХХК-ийн Бэрх уулын алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл /тодотгол/-ийг хүлээн авсанд тооцсугай.

2. Хүлээн авсан техник-эдийн засгийн үндэслэлийн үйлдвэрлэлийн нөөцийг бүртгэж, нөөцийн хөдөлгөөн хийхийг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т зөвшөөрсүгэй.

3. Техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу уулын ажил явуулах зөвшөөрөл олгох, хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т даалгасугай.

4. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан үйлдвэрийн хүчин чадал, техник, тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж байхыг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т даалгасугай.

5. Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-012325 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Бэрх уулын алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл /тодотгол/-ийг диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт энэхүү тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн Геологийн баримтын төв архивд хүлээлгэн өгөхийг Цүй Ханг Инвест ХХК -д даалгасугай.

ДАРГА

Х.ХЭРЛЭН



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДҮГНЭЛТ

2019 оны 12 сарын 12 өдөр

Дугаар Т/19-16-03

Улаанбаатар хот

Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-012325 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Бэрх Уулын алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголыг хэлэлцсэн тухай

"Цүй Ханг Инвест" ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн "Эволюшн майнинг" ХХК боловсруулсан Төв аймгийн Заамар сумын нутагт орших Бэрх Уулын алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах төслийн техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголд Монгол улсын уул уурхайн зөвлөх инженер Г.Сандагдорж зөвлөж, Монгол улсын уул уурхайн зөвлөх инженер Б.Батболд шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Техник-эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Техник-эдийн засгийн үндэслэл нь Оршил, Техник-эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, Геологийн судалгаа, Ил уурхайн олборлолт, Уурхайн ус хангамж, Баяжуулалтын технологи, Уурхайн дэд бүтэц, Үйлдвэрлэлийн удирдлага зохион байгуулалт, Байгал орчны хамгаалал, нөхөн сэргээлт, Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуй, Уурхайн хаалтын арга хэмжээ, Техник-эдийн засгийн хэсэг зэрэг 10 бүлэг, дүгнэлт бүхий 158 хуудас тайлбар бичиг, хавсралт материалууд 7 хавсралт зургуудаас бүрдэж байна.

2. Бэрх уул нэртэй MV-012325 тоот тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2007 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хурлын Дугаар 8-02 дүгнэлтийг үндэслэн гаргасан АМГТХЭГ-ын даргын 2007 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 182 дугаар тушаалаар нийт боломжтой (С) зэргээр 452,82 кг алтны нөөцийг улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

3. Төсөлд үйлдвэрлэлийн нөөцийг бодохдоо ашиглалтын үеийн хаягдал 9.46 % (4441тн хүдэр, 25.8кг), бохирдолтыг 9.94% (4691 тн) тус тус авч тооцсон ба ордыг 2 жилийн хугацаанд ашиглах бөгөөд энэ хугацаанд 612.0 мян.м³ хөрс хуулж, магадласан В' үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэн 5.21 гр/тн дундаж агуулгатай 47187 тн хүдэр олборлохоор төлөвлөсөн байна. Жилийн хүчин чадал 30.0 мян.тн бөгөөд хөрс хуулалтын итгэлцүүр 13.0 м³/тн.

4. Бэрх уулын алтны үндсэн ордыг ашиглахад эдийн засгийн үр ашигтай нөөцөд тулгуурлан ил уурхайн зардал, бүтээгдэхүүн борлуулах үнийн дагуу

буюу 1 тн нүүрсийг 110765.6 мян.төгрөгөөр борлуулах эдийн засгийн тооцоог хийж ТЭЗҮ-ийг боловсруулсан байна.

5. Уурхайн ашиглалтын системийн сонголтыг хийхдээ ордын нөөцийн тогтоц болон байршил, хөрсний зузаан, хөрсний чулуулгийн шинж чанар, зэргийг харгалзан үзэж авто тээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын системээр ашиглах нь оновчтой гэж үзжээ.

6. Тус уурхайд Cat 325C маркийн экскаватор 1ш, 25 тн даацтай Howo маркийн автосамосвал 6ш, KG940A маркийн өрмийн машин 1ш, Hyundai HL757-9 маркийн дугуйт ачигч 1 ш, D8R маркийн бульдозер 1ш зэрэг үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар ТЭЗҮ-д тусгажээ.

7. Ордын баяжуулалтын технологийн туршилт судалгааг Геологийн төв лабораторид хийлгэсэн байна.

8. Технологийн туршилтын үр дүнгээр ордын дээжинд хүдрийн эрдсүүд тааралдах боловч үйлдвэрлэлийн ач холбогдолтой эрдэс нь зөвхөн алт байна, баяжуулах технологийн туршилтаар Цианаар уусгалтын аргаар анхдагч хүдрээс, флотацийн баяжмалаас уусгахад 90% уусган авах боломжтой нь туршилтаар тогтоогдлоо гэжээ.

9. Олборлолтын явцад техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлуудыг MNS 5915:2008, MNS 5916:2008, MNS 5918:2008, MNS 5850:2008 зэрэг Монгол улсын стандарт зааварчилгааны дагуу гүйцэтгэж, тухайн бүсийн уур амьсгалын нөхцөл байдалд тохирсон ургамлаар биологийн нөхөн сэргээлтийн ажлуудыг хийж гүйцэтгэхээр зардлыг төсөлд тусгасан байна.

10. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт ба хаалтын зардалд нийт 469.8 сая төгрөг зарцуулахаар тооцсон байна. Үүнээс байгаль орчин хамгаалах зардалд 95.0 сая.төгрөг зарцуулахаар тусгажээ.

11. Уурхайн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 8123.02 сая төгрөг ба 1 кг алтыг 110765.6 мянган төгрөгөөр борлуулахаар тооцон төслийн нийт хугацаанд 44234.9 сая төгрөгийн борлуулалтын орлого олж, 26658.7 сая төгрөгийн зардал гарган, 14784.2 сая төгрөгийн цэвэр ашиг олж, хөрөнгө оруулалтаа ашиглалтын 1 жилийн хугацаанд нөхөхөөр тооцжээ.

12. Төслийн нийт хугацаанд нийт 15697.2 сая төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болох бөгөөд 10%-ийн хорогдуулалтын норм тооцсон өнөөгийн цэвэр үнэ цэнэ 5237.6 сая төгрөг, өгөөжийн дотоод норм 69.65% гарсан нь төсөл эдийн засгийн хувьд үр ашигтайгаар хэрэгжих боломжтой гэж үзжээ.

13. Төсөл хэрэгжих хугацаанд улс, орон нутгийн төсөвт 8.5 тэрбум төгрөгийг татвар төлбөр хэлбэрээр төвлөрүүлэх ба 81 хүний ажлын байр шинээр бий болохоор төсөлд тусгажээ.

14. Төсөлд шаардлагатай мэргэжлээр Монгол улсын иргэдийг бэлтгэх, тэдгээрийг ажлын байраар хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж байгаль орчныг нөхөн сэргээх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байхыг ЭБМЗ-өөс даалгаж байна.

15. Техник, эдийн засгийн үндэслэл нь уншихад ойлгомжтой, цэгц дараалал сайтай, мэргэжлийн түвшинд чанартай сайн боловсруулсан, уурхайг эхлэн байгуулж үйлдвэрлэл явуулах бүхий л шат дамжлага буюу үйл ажиллагааг хамарсан, уулын ажлын төлөвлөгөө боловсруулах зэрэгт туслах үндсэн баримт бичиг болжээ.

16. Энэхүү техник, эдийн засгийн үндэслэл нь ЭБЭХ-ийн сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074-р тушаалаар баталсан "Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам"-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.

17. Цаашид нөөцийн хөдөлгөөнийг тогтмол хөтөлж байх талаар "Цүй ханг инвест" ХХК-д зөвлөмж болгох.

18. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, цахилгаан болон усан хангамж, дэд бүтэц, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, төслийн эдийн засгийн үнэлгээг боловсруулсан Уул уурхайн зураг төслийн "Эволюшн майнинг" ХХК хариуцах, түүний үнэн бодит байдал, чанарт гаргасан дүгнэлтийг шинжээч Монгол улсын уул уурхайн зөвлөх инженер Б.Батболд хариуцах.

19. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан уурхайн хүчин чадал, техник тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж, ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж байх нь зүйтэй.

20. Захиалагч компани Техник-эдийн засгийн үндэслэлийг хүлээн авах тухай Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын шийдвэр гарснаас хойш 5 хоногт багтаан Техник-эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвд холбогдох шаардлагад нийцүүлэн хүлээлгэн өгөх үүрэгтэй. Энэ үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын дарга гаргасан шийдвэрээ түдгэлзүүлэх, цуцлах эрхтэйг анхааруулах нь зүйтэй.

Техник-эдийн засгийн үндэслэлд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Салбар хуралдаанаас Ашигт малтмал, газрын тосны газрын даргад Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн "Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-012325 тоот тусгай зөвшөөрлийн талбайтай Бэрх Уулын алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол"-ыг хүлээн авах шийдвэр гаргахыг уламжлахаар шийдвэрлэв.

ТАНИЛЦСАН:
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.МӨНХТӨР

3

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ДЭЛГЭРЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

A handwritten signature in black ink, likely belonging to the official mentioned in the text next to it.

Э.БОЛД-ЭРДЭНЭ

MV-012325 тоот тусгай зөвшөөрөл бүхий Төв аймгийн Заамар сумын нутагт орш

Ашиглалтын түвшин	Боловсролын дүрвэр	Геологийн нөөц /2007 онд батлагдсан/					Сэлбэрлэлтэнд өртсөн /2019 оны 10.30/					2019 оны нутаг
		Талбай, м²	Худрийн нөөц		Дундаж агуулга, г/т	Алт, кг	Талбай, м²	Худрийн нөөц		Дундаж агуулга, г/т	Алт, кг	
			м³	тн				м³	тн			
+1003м-о доош	C-1	106.7	187.8	482.8	2.6	1.3	106.7	187.8	482.8	2.6	1.3	0
	C-2	362.2	641.1	1648.0	7.21	11.9	362.2	641.1	1648.0	7.21	11.9	0
	C-3	151.2	270.6	695.4	16.34	11.4	151.2	270.6	695.4	16.34	11.4	0
	C-4	136.6	394.7	1014.7	5.58	5.7	136.6	394.7	1014.7	5.58	5.7	0
	C-5	313.3	939.9	2415.3	5.52	13.3	313.3	939.9	2415.3	5.52	13.3	0
	C-6	221.5	1127.5	2897.4	2.58	7.5	221.5	1127.5	2897.4	2.58	7.5	0
	C-7	137.6	838.0	2153.6	5.05	10.9	137.6	838.0	2153.6	5.05	10.9	0
	C-8	6.6	40.7	104.6	8.52	0.9	6.6	40.7	104.6	8.52	0.9	0
	Нийт	1435.7	4440.3	11411.9	5.50	62.7	1435.7	4440.3	11411.9	5.50	62.7	0.0
+993м-е +1003м	C-1	138.4	243.6	625.6	2.6	1.6	138.4	243.6	625.6	2.6	1.6	0
	C-2	404.1	715.2	1838.6	7.21	13.3	404.1	715.2	1838.6	7.21	13.3	0
	C-3	107.9	193.1	496.8	16.34	8.1	107.9	193.1	496.8	16.34	8.1	0
	C-4	128.5	371.4	954.2	5.58	5.3	128.5	371.4	954.2	5.58	5.3	0
	C-5	379.5	1138.5	2925.6	5.52	16.1	379.5	1138.5	2925.6	5.52	16.1	0
	C-6	215.4	1096.4	2817.6	2.58	7.3	215.4	1096.4	2817.6	2.58	7.3	0
	C-7	226	1376.3	3537.4	5.05	17.9	226	1376.3	3537.4	5.05	17.9	0
	C-8	124.4	767.5	1972.7	8.52	16.8	124.4	767.5	1972.7	8.52	16.8	0
	Нийт	1724.2	5902.1	15168.5	5.70	86.4	1724.2	5902.1	15168.5	5.70	86.4	0.0
+983м-е +993м	C-1	152.7	268.8	690.5	2.6	1.8	45	79.2	203.5	2.6	0.5	107.7
	C-2	467.1	826.8	2124.3	7.21	15.3	48	85.0	218.3	7.21	1.6	419.1
	C-3	142.3	254.7	655.0	16.34	10.7	68	121.7	313.0	16.34	5.1	74.3
	C-4	136.7	395.1	1015.0	5.58	5.7	40	115.6	297.0	5.58	1.7	96.7
	C-5	500.2	1500.6	3856.1	5.52	21.3	89	267.0	686.1	5.52	3.8	411.2
	C-6	265.8	1352.9	3476.9	2.58	9.0	36	183.2	470.9	2.58	1.2	229.8
	C-7	310.2	1889.1	4855.1	5.05	24.5	60	365.4	939.1	5.05	4.7	250.2
	C-8	264.3	1630.7	4190.5	8.52	35.7	100	617.0	1585.5	8.52	13.5	164.3
	Нийт	2239.3	8118.7	20863.4	5.94	124.0	486.0	1834.1	4713.4	6.82	32.1	1753.3
+973м-е +983м	C-1	59.1	104	267	2.6	0.7	0	0	0	-	0	59.1
	C-2	407.5	721.3	1854	7.21	13.4	0	0	0	-	0	407.5
	C-3	19.9	35.6	92	16.34	1.5	0	0	0	-	0	19.9
	C-4	53.7	155.2	399	5.58	2.2	0	0	0	-	0	53.7
	C-5	327.6	982.8	2526	5.52	13.9	0	0	0	-	0	327.6
	C-6	199.4	1014.9	2608	2.58	6.7	0	0	0	-	0	199.4
	C-7	250.4	1524.9	3919	5.05	19.8	0	0	0	-	0	250.4
	C-8	164.2	1013.1	2604	8.52	22.2	0	0	0	-	0	164.2
	Нийт	1481.8	5551.8	14269.0	5.64	80.4	0.0	0.0	0.0	-	0.0	1481.8
+963м-е +973м	C-1	15.7	27.6	71	2.6	0.2	0	0	0	-	0	15.7
	C-2	145.9	258.2	664	7.21	4.8	0	0	0	-	0	145.9
	C-4	9.5	27.5	71	5.58	0.4	0	0	0	-	0	9.5
	C-5	60.1	180.3	463	5.52	2.6	0	0	0	-	0	60.1
	C-6	92.9	472.9	1215	2.58	3.1	0	0	0	-	0	92.9
	C-7	250.6	1526.2	3922	5.05	19.8	0	0	0	-	0	250.6
	C-8	164.1	1012.5	2602	8.52	22.2	0	0	0	-	0	164.1
	Нийт	738.8	3505.2	9008.0	5.89	53.0	0.0	0.0	0.0	-	0.0	738.8
	+953м-е +963м	C-6	17.5	89.1	229	2.58	0.6	0	0	0	-	0
C-7		208.2	1267.9	3259	5.05	16.3	0	0	0	-	0	208.2
C-8		131.4	810.7	2084	8.52	17.8	0	0	0	-	0	131.4
Нийт		357.1	2167.7	5572	6.25	34.8	0	0	0	-	0	357.1
943м-е +953м	C-7	93	566.4	1456	5.05	7.4	0	0	0	-	0	93
	C-8	30.4	187.6	482	8.52	4.1	0	0	0	-	0	30.4
	Нийт	123.4	754.0	1938.0	8.91	11.5	0.0	0.0	0.0	-	0.0	123.4
Бүгд	8100.3	30439.8	78229.9	5.79	452.8	3645.9	12176.5	31293.7	5.79	181.3	4454.4	

Ордыг 2019 онд ашиглаж эхлэсэн бөгөөд 2019 оны 10-р сарын 30-ны өдрийн байдлаар "Эволюшн сүрвэл" нөөцийн хэмжээг тооцоолдоо.

Уул уурхайн сайдын 2015 оны 09-р сарын 11-ний өдрийн 203 тоот тушаалаар батлагдсан "Ашигт малтмал нөөцийг магадласан (В) үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэн тооцоо.

Нөөцийн тооцоог хийсэн:

Төслийн инженер Ж.Билүүн



ЦҮЙ ХАНГ ИНВЕСТ ХХК-Д

**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,
Утас: 26 19 66, Факс: (976-51) 26 61 71,
E-mail: contact@mne.gov.mn, http://www.mne.mn

2019.02.02 № 15/785
танай _____-ны № _____-т

**Ерөнхий үнэлгээний дүгнэлт
хүргүүлэх тухай**

Танай компаниас боловсруулж ирүүлсэн Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-012325 дугаартай тусгай зөвшөөрөлтэй Бэрх уулын амны алтны үндсэн ордыг ашиглах төсөлд "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, "Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам"-ын 3 дахь хэсгийг үндэслэн, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлалын дагуу ерөнхий үнэлгээ хийлээ.

Ерөнхий үнэлгээний дүнгээр уг төсөлд батлагдсан аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзэв.

Төсөл хэрэгжүүлэгч нь Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудаст заасан нарийвчилсан үнэлгээний явцад тодруулах асуудлууд, онцгойлон анхаарах чиглэлийг харгалзан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж 2019 оны 3 дугаар улиралд багтаан тус яаманд ирүүлэхийг үүгээр мэдэгдье.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудсыг хавсаргав.

ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ

А.ЭНХБАТ

370505

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУУДАС

2019 оны 02-р сарын 02

Улаанбаатар хот

Төслийн дугаар

Дугаар 2019/Т-027

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: "Цүй ханг инвест" ХХК, регистрийн дугаар-6342485, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 1 дүгээр хороо, Богд ар, 2а-14 тоот.

Төслийн нэр: Алтны үндсэн орд ашиглах

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил: Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-012325 дугаартай тусгай зөвшөөрөлтэй "Бэрх уул" талбайд хэрэгжинэ.

Холбоо барих утас: 976-11-362073



Орон нутгийн санал: Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 1/22 тоот саналыг харгалзав.

Төслийн нэр	Төслийн үндсэн зорилго	Мөнгө	Мөнгөний үнэмлэхүй үнэ	Тийм/Хийгээгүй	Тайлбар
Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн нийцэл	Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа байгаль орчныг хамгаалах болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн холбогдох заалт			Тийм	Нарийвчилсан үнэлгээний явцад хууль тогтоомжийн нийцлийг нарийвчлан тодорхойлох
Төрийн бодлого, шийдвэрийн нийцэл	Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Стратегийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн холбогдох заалт			Тийм	
Төслийн байршил, түүнтэй холбогдох шалгуурууд	Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх (урсац бүрэлдэх эх, ойн болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, хилийн хамгаалалтын бүс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар г.м)			Тийм	
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь хүний нөлөө, байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг, мэдрэмтэй эсэх			Тийм	
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд улс, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн, сөрөг нөлөөлд өртөж болохгүй газар байгаа эсэх			Тийм	
	Боловсрол хуримтлагдах нөлөөлөл үүсгэх эсэх			Тийм	
Төслийн байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Агаарын чанар				
	Бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгаруулах эсэх			Тийм	
	Дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсэх эсэх			Тийм	
	Усан орчин				
	Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх эсэх			Тийм	
	Цэцэг усны нөөцийг ашиглах эсэх			Тийм	
	Гадаргын болон газрын доорх усанд бохирдол үүсэх эсэх			Тийм	

Хөрсөн бүрхэвч					
	Хөрсөн бүрхэвч андрах, эсэх			Тийм	
	Хөрс бохирдуулах эсэх			Тийм	
	Хөрс доройтох, цөлжих эсэх			Тийм	
Ургамлан нөмрөг					
	Ургамлан нөмрөг, ой мод өртөх эсэх			Тийм	
	Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйлс өртөх, эсэх			Тийм	
Амьтны аймаг					
	Зэрлэг амьтдын амьдрах орчинг доройтуулах, эсэх			Тийм	
	Ховор, нэн ховор амьтан өртөх, эсэх			Тийм	
Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Нутгийн оршин суугчид				
		Газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөх, эсэх			Тийм
		Нутгийн оршин суугчдын нийгмийн байдалд сөрөг нөлөөлтэй, эсэх			Тийм
		Нөлөөлд өртөх болзошгүй төв, суурин газар байгаа, эсэх			Тийм
		Нүүлэн шилжүүлэх асуудал үүсэх, эсэх			Тийм
	Түүх, соёлын биет өв				
		Сөрөг нөлөөлд өртөх түүх, соёлын үнэт зүйлс бий эсэх			Тийм
	Хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл				
		Нутгийн иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эсэх			Тийм
		Төслийн бүх үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд эрсдэл үүсэх эсэх			Тийм
Нэгдсэн дүгнэлт:					
Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-012325 дугаартай тусгай зөвшөөрөлтэй "Бэрх уул" алтны үндсэн ордыг ашиглах төсөлд хийсэн Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлээр уг төсөлд шинээр батлагдсан аргачлалын дагуу Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзлээ.					
Онцгойлон анхаарах зүйлс:					
<p>1. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг батлагдсан Техник эдийн засгийн үндэслэлд тулгуурлан хийлгэх бөгөөд олборлолт, боловсруулалтын технологийн дарааллыг нарийвчлан тодорхойлж, технологийн сонголтод үнэлэлт дүгнэлт өгөх; /Төслийн техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийгдсэн тохиолдолд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд заасны дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд тодотгол хийлгэх шаардлагатай/</p> <p>2. Төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, байгаль орчин /ургамал, хөрс, ус, амьтан, агаар/-д үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүний хамрах хүрээ, учруулах хохирлын хэмжээг урьдчилан тооцож, нийлбэр үнэлгээ гарган төслийг хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар дүгнэлт гаргах;</p> <p>3. Тухайн орд газрын гадаргын болон газрын доорх усны харилцан хамаарал, уст үеийн хөдөлгөөн, тархалтыг олборлох технологитой уялдуулан нарийвчлан судалж, төсөл хэрэгжүүлэгчийн сонгосон аргаар байгаль орчин, хүний эрүүл мэндэд халгүйгээр тухайн ордыг ашиглах боломжтой эсэхийг тодорхойлж, дүгнэлт өгөх;</p> <p>4. Алт олборлох болон төслийн бүрэлдэхүүн хэсгээс ялгарах бохирдлын хэмжээ, түүний тархалт, нөлөөллийг хүрээг нарийвчлан тодорхойлж, зураглал үйлдэн тайланд хавсаргах;</p> <p>5. Ордын ашиглалт дууссаны дараах хаалтын нөхөн сэргээлт, мониторинг хийх төслийг боловсруулж, хаалтын ажлын каледарчилсан төлөвлөгөө, зардлын тооцоог урьдчилан тооцох;</p> <p>6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр/-г боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө,</p>					

- зардлыг эхний 5 жилээр тооцож ирүүлэх;
7. "Байгаль орчныг хамгаалах тухай" хуулийн 10¹-р зүйлд заасны дагуу төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд байгаль орчны төлөвлөгөөт аудитыг төслийн 2 дахь жилээс хийлгэх, аудитын дүгнэлт зөвлөмжийг холбогдох газруудад хүргүүлэх хугацаа, зардлыг тайланд тусгах;
 8. Төсөл хэрэгжихээс өмнө тухай уурхайн эдалбэр газарт Газрын төлөв байдлын чанарын хянан баталгааг хийлгэж, цаашид 2 жил тутамд мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж байхыг тайланд тусгах;
 9. Нарийвчилсан үнэлгээ хийх явцад уг төсөл хэрэгжиснээр байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөллийн талаар болон БОННУ-ний ажлын тайланг төсөл хэрэгжих багийн ИНХ-аар хэлэлцүүлж, хурлын тэмдэглэл, шийдвэр болон сумын Засаг даргын /ИТХ/ саналыг авч тайланд хавсаргах;
 10. Төслөөс ойд үзүүлэх сөрөг нөлөөллийг нарийвчлан судалж, тайланд тусгах;
 11. Уурхайн үйл ажиллагаанаас гарсан хаягдлыг хэрхэн зайлуулах, түүнээс байгаль орчин учирч болох сөрөг нөлөөллийг нарийвчлан тооцож тайланд тусгах;
 12. Төсөлд ашиглах усны хэмжээг батлагдсан аргачлалын дагуу тооцоолох, усны нөөцийн эх үүсвэр хүрэлцээтэй эсэх талаар холбогдох байгууллага, нэгжээс дүгнэлт гаргуулах;
 13. Төсөлд ашиглах авто замын трассыг тогтоох, авто тээврийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тооцоолох, бууруулах зөвлөмж боловсруулж тайланд тусгах;

Заавал хэрэгжүүлэх шаардлагатай дээр дурдсан арга хэмжээг цаг хугацаанд нь ханган биелүүлээгүй тохиолдолд ерөнхий үнэлгээний дүгнэлтийг хүчингүй болгож "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийн дагуу хариуцлага тооцохыг урьдчилан мэдэгдье.

<p>Ерөнхий үнэлгээ хийсэн: Байгаль орчин, аялал жуулчлалын яамны шинжээч</p>  <p>Д.ТЭМҮҮЛИН</p>	<p>Ерөнхий үнэлгээний үр дүнг зөвшөөрсөн: "Цүй ханг инвест" ХХК-ийн гүйцэтгэх захирал</p>  <p>ХУАН ЮНЖИЕ</p>
--	---



**ҮРЖҮҮЛГИЙН МОД
БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ**

2022 оны 10-р сарын 14-ний өдөр

№ 10/28

Улаанбаатар хот

Энэхүү "Үржүүлгийн мод бэлтгэн нийлүүлэх гэрээ" (цаашид "Гэрээ" гэх) -г

Нэг талаас: Монгол улс, Баянзүрх дүүрэг, 10-р хороо, Жон Юань Бульдинг, 402 тоот хаягт оршин байрлах "ЦҮЙ ХАНГ ИНВЕСТ" ХХК / цаашид "Захиалагч" гэх /, түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Хуан Юнжие,
Нөгөө талаас: Улаанбаатар хот Баянгол дүүрэг, 6-р хороо, 10-р хороолол, Энхтайвны өргөн чөлөө, 57-2 байр 73 тоот хаягт оршин байрлах "Сүхэспартнерс" ХХК / цаашид "Нийлүүлэгч" гэх / түүнийг төлөөлж менежер Д.Сүхбаатар.

нар (цаашид хамтад нь "талууд" гэх) Монгол Улсын Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн дор дурдсан нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү гэрээгээр нийлүүлэгч нь Захиалагчид Төв аймгийн Эрдэнэцогт суманд өөрийн тарьж ургуулсан хайлаас модыг нийлүүлэх, Захиалагч тал гэрээнд зөвшөөрсөн төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2 Талууд гэрээг харилцан зөвшөөрч гарын үсэг зурж, тамга тэмдэг дарсан өдрөөс хучин төгөлдөр болно.

Хоёр. Талуудын үндсэн тохиролцоо

- 2.1. Нийлүүлэгч нь энэхүү гэрээний дагуу 4,000 ширхэг хайлаас модыг нийлүүлнэ.
- 2.2. Нийлүүлэгч нь гэрээний зүйлийг Төв аймгийн Баянцогт суманд өөрийн талбай дээрх нөхцдөөр нийлүүлэх ба Захиалагч нь өөрийн талбай хүртэл тээвэрлэхтэй холбоотой бүхий л зардал, эрсдэлийг бүрэн хариуцна.
- 2.3. **Гэрээний үнэ:** 1 ширхэг 0.4-0.5 метр өндөртэй хайлаас мод нь 2000 /Хоёр мянга/ төгрөг байх бөгөөд энэхүү гэрээний нийт үнэ нь 8,000,000 /Найман сая/ төгрөг байна.
- 2.4. **Хугацаа:** Захиалагч энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурж хучин төгөлдөр болсон өдрөөс хойш 3 хоногийн дотор урьдчилгаа төлбөр төлж гэрээг баталгаажуулна. Захиалагч нь урьдчилгаа төлбөр төлсөнөөс хойш өөрийн мод тариалах плантацийг бэлтгэж дуусгалаа тус үржүүлгийн талбайд хуанлийн 2 жил хүртэлх хугацааны дотор хадгалж болно, 2 жилээс хэтэрсэн нөхцөлд эзэлхүүний хэмжээгээр талбайн түрээс төлнө.
- 2.5. **Нийлүүлэлт:** Төв аймгийн Баянцогт суман дахь нийлүүлэгчийн талбайгаас хүлээн авна. Хүн цагийн төлбөр тохиролцсон нөхцөлд хөрстэй шуудайд эсвэл тус бүрчилсэн бортогонд сав баглаанд хийж өгч үйлчилж болно.
- 2.6. **Тээвэрлэлт:** Захиалагч өөрийн тээврийн зардаар модны суулгацыг тээвэрлэн авч явах ба тээвэрлэлт, хадгалалт, хамгаалалтыг өөрөө бүрэн хариуцна.
- 2.7. **Хуцгах хэмжээ:** Энэхүү гэрээний дагуу нийлүүлсэн бүтээгдэхүүний хуцгах хэмжээ нь 0,5% байна.
- 2.8. Нийлүүлэгч нь захиалагчид биет байдлын доголдолгүй, бүтээгдэхүүнийг нийлүүлэх үүрэгтэй.

- 2.9. Нийлүүлэгч гэрээний зүйлийг нийлүүлж акт үйлдсэнээр тухайн нийлүүлсэн бүтээгдэхүүнтэй холбоотой бүхий л эрсдэл захиалагч талд шилжих нийлүүлснээс хойших бүтээгдэхүүний чанар байдал, тоо, ширхэг, хадгалалтыг захиалагч бүрэн хариуцна.
- 2.10. Нийлүүлэгч нь модыг захиалагчид өгөх үед талууд хамтран акт үйлдэж хүтээлгэн өгнө.
- 2.11. Захиалагч, Гүйцэтгэгч нар Ажлын гүйцэтгэлийг хамтран шалгаж хүлээлцэх тухай актанд гарын үсэг зурснаар Ажлыг хүтээлгэн өгсөнд тооцно.

Гурав. Талуудын хүлээх үүрэг

- 3.1. Энэхүү гэрээний 2.1 - т заасан нийлүүлэлтийг хийхийн тулд Талууд дараах үүргийг харилцан адил хүлээж, дор дурдсан эрхийг эдэлнэ.
- 3.2. Талуудын хүлээх үүрэг:
 - 3.2.1. Харилцан тэгш эрхтэй байх;
 - 3.2.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх;
 - 3.2.3. Гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээх;
 - 3.2.4. Аль нэг тал нь буруутай үйл ажиллагааныхаа улмаас нөгөө талдаа учруулсан хохирлоо нөхөн төлөх;
 - 3.2.5. Гэрээний зүйлийг хүлээн авахдаа акт / актыг зургаар баталгаажуулах / үйлдэх;
 - 3.2.6. Гэрээгээр хүлээсэн анзыг / торгууль, алданги / ул маргах журмаар төлөх;
 - 3.2.7. Гэрээнээс үүдэлтэй санал, зөрөлдөөн маргаантай асуудлыг аль болох зөвшилцлийн аргаар шийдвэрлэх зэрэг үүргүүдийг талууд хамтран хүлээнэ.
- 3.3. Талуудын эдлэх эрх:
 - 3.3.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг нөгөө талаасаа шаардах;
 - 3.3.2. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах;
 - 3.3.3. Гэрээг цуцлах болон дуусгавар болгох санал гаргах;
 - 3.3.4. Өөрт учирсан хохирлоо арилгуулах тухайгаа нөгөө талаасаа шаардах;

Дөрөв. Төлбөр тооцоо

- 4.1. Энэхүү гэрээний нийт төлбөр нь 8,000,000 /Найман сая / төгрөг байх бөгөөд Захиалагч нь төлбөрийг дараах графикийн дагуу төлнө.

№	Нэр	Төлбөрийн 50% гэрээ баталгаажсан өдөр	Төлбөрийн 25%	Бараа шилжүүлж авахдаа 25%
1	Хайшас мод	2022/10/14	2023/05/12	2023/10/05
2				

- 4.2. Гэрээний төлбөрийг нийлүүлэгч компанийн ХААН банкны 54-31-54-08-81 тоот дансанд төлнө.
- 4.3. Захиалагч нь төлбөр төлөх хугацаа хэтрүүлсэн тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд төлбөл зохих үнийн дүнгийн 0.3 % хувийн алданги төлнө.

Тав. Гэрээ дуусгавар болох цуцлах журам

- 5.1. Энэхүү гэрээ нь дор дурдсан үндэслэлээр дуусгавар болно. Үүнд:
 - 5.1.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ харилцан гүйцэтгэж, акт үйлдсэнээр.
- 5.2. Гэрээний аль нэг тал нөгөө талын буруутай үйл ажиллагааны улмаас гэрээг цуцлах бол ажлын 14-с доошгүй хоногийн өмнө бичгээр урьдчилан мэдэгдэнэ.
- 5.3. Дараах тохиолдолд талууд гэрээг дангаар цуцална. Үүнд:
 - 5.3.1. Захиалагч нь гэрээнд заасан хугацаанд төлбөрөө төлөөгүй бол нийлүүлэгчийн санаачилгаар гэрээг цуцална.
 - 5.3.2. Нийлүүлэгч нь Захиалагчийн тогтоосон хугацаанд бараа бүтээгдэхүүн бэлэн бус бол Захиалагчийн санаачилгаар гэрээг цуцална.
 - 5.3.3. Давагдашгүй хүчин зүйл (үер ус, газар хөдлөлт, гал түймэр зэрэг байгалийн гамшиг, дайн байлдаан, экспорт импортын хориг зэрэг Төрийн байгууллагын акт нь үүргээ биелүүлэхэд нөлөөлсөн буюу эрх бүхий шүүх, арбитрын байгууллагын дүгнэлт тогтоолоор баталгаажсан) тохиолдол




- 5.4. Гэрээний аль нэг тал ногоо талдаа урьдчилан мэдэгдэлгүйгээр сайн дураар гэрээнээс татгалзах эрхгүй.

Зургаа. Бусад

- 6.1 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр тэмдэглэл үйлдэн гэрээнд өөрчлөлт оруулж болно.
- 6.2 Талууд доорх албан ёсны хаягаар мэдэгдэл хүргүүлснийг албан ёсоор хүргүүлсэнд тооцох ба доорх хаяг өөрчлөгдөх тохиолдолд нөгөө талдаа мэдэгдэнэ.
- 6.3 Талуудын удирдлага, өмчлөгч өөрчлөгдсөн нь энэхүү гэрээг цуцлах, өөрчлөх үндэслэл болохгүй. Маргаантай асуудал гарвал талуудын ажлын хэсэг хамтарч хэлэлцэн шийдвэр гаргана. Талууд шийдэлд эс хүрвэл Монгол улсын хууль, тогтоомжийн дагуу холбогдох шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 6.4 Гэрээг 2 хувь үйлдэж, тал тус бүр нэг нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн аани хүчин чадалтай байна.
- 6.5 Энэхүү гэрээгээр зохицуулаагүй аливаа харилцааг Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн дагуу зохицуулна.
- 6.6 Энэхүү гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхтэй холбоотой аливаа харилцааг зөвхөн энэ гэрээгээр зохицуулна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:



		МОНГОЛ УЛС ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ		
000237839				
2021.09.10 <i>/ Бүртгэсэн он, сар, өдөр /</i>		9011831362 <i>/ Хуулийн хэргийн дугаар /</i>		
		6754597 <i>/ Регистрийн дугаар /</i>		
Сүхэс партнерс		Хязгаарлагдмал хариуцлагатай компани		
<i>/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /</i>				
Дүрэм <i>/ Үүсэн байгуулах баримт бичиг /</i>				
Шийдвэр <i>/ шийдвэрийн нэр /</i>		01 <i>/ дугаар /</i>		2021.09.09 <i>/ он, сар, өдөр /</i>
70200		Менежментийн зөвлөгөө өгөх		
66190		Саяхүүгийн тайлан баланс гаргах түүнтэй холбоотой зөвлөгөө өгөх		
82990		Бизнесийн зөвлөгөө өгөх		
82110		Уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх		
71102		Геологийн суурь судалгаа зөвлөгөө өгөх		
46630		Барилгын материалын худалдаа		
45300		Авто машины худалдаа		
<i>/ Код /</i>		<i>/ Үйл ажиллагааны чиглэл /</i>		
Хугацаагүй <i>/ хугацаа /</i>		1 <i>/ шилүүдийн тоо /</i>		4.00 <i>/ хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /</i>
Улаанбаатар, Баянгол, 6-р хороо, 10-р хороолол, анхтайваны өргөн чөлөө, 57-2, 73 тоот, Утас1: 80889087, Утас2: , Факс:				
<i>/ хуулийн этгээдийн өлбөг бичиг хаяг /</i>				
		УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР <i>/ Бүртгэсэн байгууллагын нэр /</i>		
		УЛСЫН БҮРТГЭГЧ <i>(гэмдэгч)</i>		Н.ДОРЖАВ <i>(архивчсан)</i>

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Сүхбаатар овогтой Баторшил-а Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгээ.	2021.09.10	Н.Долгоржав



Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүдээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

000237839

Усны дүгнэлт, ашиглах гэрээ, зөвшөөрөл, төлбөрийн баримт



**ТӨВ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

41111 Төв аймаг, Зуунмод сум, Номт 1 дүгээр баг

Утас: 70273290, 70272457

Цахим шуудан: tuv.boajg@gmail.com

Цахим хаяг: baigali.to.gov.mn

2023.05.15 № 07/177

танай _____ -ны № _____ -т

**“ЦҮЙ ХАН ИНВЕСТ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ ХУАН ЮНЖИЕ ТАНАА**

**“Цүй хан инвест” ХХК-д ус ашиглуулах
дүгнэлт хүргүүлэх тухай**

Төв аймгийн Заамар сум, Тосон баг, Бэрх Уул нэртэй MV-012325 тусгай зөвшөөрлийн дугаартай талбайн 2023 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг судлан үзээд “Усны тухай” хуулийн 4 дүгээр бүлгийн 28 дугаар зүйлийн 4 дэх заалтыг үндэслэн 2022 онд усны нөөц ашиглуулах тухай дүгнэлтийг гарган хүргүүлж байна.

Усны нөөц ашигласны төлбөрийг аймгийн төсөвт (Төв аймгийн Татварын хэлтсийн “Төв аймаг төрийн сан банк” дахь 100140000944 тоот дансанд), БОАЖ-ийн сайдын 2018 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/376 тоот тушаалаар батлагдсан ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс 50000 төгрөгийг Төв аймаг Төрийн сан дахь /Тө.БОАЖГ н.с/ 100140013402 тоот дансанд тус тус төлөх нь зүйтэй.

Усны тухай хуулийн 28.6, 28.11-д заасны дагуу сумын Засаг даргаас ус ашиглах зөвшөөрөл аван, ус ашиглах гэрээ байгуулах, усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбоотой мэдээ тайланг дүгнэлтэд заасан хугацаанд ирүүлэх, ус ашиглуулах тухай дүгнэлтээр өгсөн зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлэн ажиллахыг мэдэгдье.

Хавсралт__хуудастай.

Хувийг Заамар сумын Засаг даргад

ДАРГА



Ж. ДАШ-ЯЙЧИЛ

412306000106

ТӨВ АЙМАГ БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР
УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ
Дугаар22/26

2023.05.12

Зуунмод

1.Аж ахуйн нэгж байгууллага,захирлын нэр хаяг, утас факс, улсын бүртгэлийн дугаар

“Цүй хан инвест” ХХК, Захирал Хуйн Юнжие, Улаанбаатар, Баянгол дүүрэг, 1-р хороо, Богд Ар, 2а, 14 тоот, УБД:9019089073, РД:6342485, Утас:99095658

2.Төслийн нэр, байршил: Төв аймаг, Заамар сум

3. Төсөл хэрэгжүүлэгч: “Цүй хан инвест” ХХК

4. Төслийн газарзүйн байршил: Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар MV-012325, 506.0 га талбайг хамарна.

№	Х	Ү	Талбай
1.	104° 35'40"	48° 31'40"	506.0 га
2.	104° 35'40"	48° 33'00"	
